



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-27</i>
<hr/>	
<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i>	<i>4-5</i>
<i>2.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг буруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>5-27</i>

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
04 дүгээр сарын 11-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 30 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Ганибал, Г.Дамдинням, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Батжаргал тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг санал хэлэв.

Ж.Батжаргал: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	0
Бүгд:	13

100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Г.Мөнхцэцэг, Ц.Туваан нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг буруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, референт О.Дөлгөөнтуул, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Сонор, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал С.Цогтсайхан, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Г.Ганболд, Г.Мөнхцэцэг, Ц.Анандбазар, Т.Энхтүвшин, Ц.Цэрэнпунцаг, Х.Болорчулуун, Ц.Туваан, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Болорчулуун нар үг хэлэв.

Ж.Батжаргал: Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг буруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 26 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 56 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Үндсэн хууль”
танхим 13 цаг 30 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанд Байнгын хорооны гишүүн Батжаргал, Бат-Эрдэнэ, Саранчимэг, Бейсен, Ганболд, Идэрбат, Мөнхцэцэг, Наранбаатар, Тэмүүлэн, Энхтүвшин, Болорчулуун нар хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52.6 хувьтай байх тул өнөөдрийн Байнгын хороо хорооны хуралдааныг эхлүүлье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэнэ.

Байнгын хорооны тогтоолын төсөл Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай асуудал байна.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүд Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудал.

Ийм 2 асуудал хэлэлцэхээр орж ирсэн байна.

Нэг нь хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулах тухай асуудал.

Нэг нь Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудал.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулттай, саналтай гишүүд байна уу? Байхгүй байгаа тул Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг баталлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн тул хэлэлцүүлэгт бэлтгэх санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг байгуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооноос тогтоох нь:

1. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Ганзоригийн Тэмүүлэн Улсын Их Хурлын гишүүн, гишүүдэд Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Ц.Туваан, Т.Энхтүвшин 2 ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжилтнүүдийг тухай бүр нь татан оролцуулахыг Ажлын хэсэг Г.Тэмүүлэн зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төслөөс асуух зүйл бий юу? Энэ хуулийн төсөл дээр манай Байнгын хорооны гишүүдийн 16 нь санаачлагчаар орчихсон учраас Улсын Их Хурлын тухай хууль болоод Дэгийн хуульд хязгаарлачихсан юм байхгүй юм билээ. Тийм учраас тодорхой гишүүдээ оруулахаас өөр ажлын хэсэгт орох бололцоо бий.

Мөнхцэцэг гишүүн.

Г.Мөнхцэцэг: Ер нь нөгөө дэг зөрчихгүй байгаа учраас санаачлагчаас бас ажлын хэсэгт орж болох ийм дэгтэй, дэг бас байгаа учраас миний бие бас энэ ажлын хэсэгт орж ажиллая гэсэн нэрээ оруулж, энэ санал гаргаж байна.

Ж.Батжаргал: Өөр саналтай гишүүн бий юу? Өөр байна уу? Нэг гишүүн нэммээр байна. Зургаа болчихоод байдаг. Тэгье тэгье. Тэгвэл саяын танилцуулсан нэрсээс Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин татаад, Г.Мөнхцэцэг гишүүн орох санал илэрхийлсэн тул Тэмүүлэн, Анандбазар, Батжаргал, Туваан, Г.Мөнхцэцэг гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийг байгуулъя гэсэн ийм санал байна. Өөр санал бий юу? Санал байхгүй байна. Тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Баярлалаа.

13.38 цагт

Хэлэлцэх асуудлын дараалал ёсоор дараагийн асуудалдаа оръё. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж эхэлъе.

Хууль санаачлагчийн танилцуулга мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн ЗГХЭГ-ын дарга Амарбаясгалан дарга танилцуулна. Амарбаясгалан даргын микрофоныг өгъе. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Д.Амарбаясгалан: Эрхэм Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого алсын хараа 2050-ийн тогтвортой хөдөө аж ахуйн 8.3-д хөдөө аж ахуйг байгальд ээлтэй уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ гэсэн зорилт дэвшүүлсэн. Энэхүү зорилтын хүрэх хүрээнд нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх хөдөө аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг төрөлжүүлж, кластер, логистик, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлж төлөвшиүүлэх хөдөө аж ахуйн салбарын хүний хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, ая тухтай амьдрах нөхцөлийг, нийгмийн баталгааг сайжруулах хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гадаад зах зах зээлийг тэлж, зарим нэр төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний импортыг халж экспортыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг 2030 он хүртэл авч хэрэгжүүлэхээр зорьсон мал аж ахуйн ДНБ-ий 10.5 хувь, ажиллах хүчний 21.6 хувийг бүрдүүлж байгаа. Монгол Улсын нийгэм эдийн засгийн тогтвортой байдал цаашидын хөгжилд чухал үүрэгтэй салбар юм аа. Гэвч дэлхийн дулаарлаас үүдэн сүүлийн 80 жилд агаарын жилийн дундаж температур 2.36 градусаар нэмэгдэж хур тунадасны хэмжээ 7 хувиар буурч 3-аас 4 жил тутамд ган зуд тохиож байгаа нь мал аж ахуйн салбарт томоохон сорилт хүндрэлийг бий болгож байна аа. Сүүлийн 70 гаруй жилд манай оронд 13 удаагийн зудын улмаас нийт 45 сая толгой мал зүй бусаар хорогдсон бөгөөд 2010 онд нийт малын 22 хувь хорогдож 8.6 мянган малчин өрх малгүй болж байсан. Энэ оны өвөлжилт хаваржилтын хүндрэлийн улмаас 4 дүгээр сарын 8-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт малын 9.6 хувь буюу 6.3 сая мал хорогдоод байна. Малынхаа 70 хувийг алдсан 1521 өрх 80

хувийг алдсан 732 өрх 90 хувийг алдсан 326 өрх, огт малгүй болсон 380 өрх байна аа.

Иймд гамшигийн эрсдэл бодитой бий болсон нөхцөл байдал гамшигт өртсөн малчдын амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг цаг алдалгүй авах шаардлагатай байгааг тус тус харгалзан Монгол Улсын Засгийн газраас уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулан хэлэлцүүлж байна аа. Хуулийн төслөөр мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд тэсвэртэй болгох, эрсдэлийг бууруулах, даван туулах арга хэмжээг тодорхойлсон.

Түүнчлэн малчид амьжиргаагаа дээшлүүлэх нийтлэг хэрэгцээ хангах мал аж ахуйн бүтээгдэхүүний эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд сайн дураар хамтрах хоршоонд нэгдэх санаачилгыг дэмжих замаар мал аж ахуйн салбарын тогтвортой үр ашигтай хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тусгасан. Мөн малчны хоршоонд нэгдсэн малчид Зээлийн батлан даалтын сан 100 хүртэл хувийн баталгаа гаргаж арилжааны банкны эх үүсвэрээр зээл олгох, малчны анхан шатын болон дунд дундын хоршооны загварыг бүс нутгийн онцлогтой нийцүүлэн тодорхойлох, малын тэжээл, таримал ургамлаа өөрсдөө тарих боломжийг бүрдүүлэх төрийн дэмжлэгт хамрагдсан малчны хүлээх үүргийн талаар тусгасан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Газрын тухай, Зээлийн батлан даалтын тухай, Хоршооны тухай зэрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье ээ.

Ж.Батжаргал: Амарбаясгалан сайдад баярлалаа.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Амарбаясгалан Монгол Улсын ЗГХЭГ-ын дарга, Болорчулуун ХХААХҮ-ийн сайд, Ганхөлөг ХХААХҮ-ийн дэд сайд, Дондогмаа ЗГХЭГ-ын Хууль эрх зүйн газрын дарга, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга, Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө оруулалт удирдлагын хэлтсийн дарга, Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Цогтсайхан Зээлийн батлан даалтын сангийн захирал Дөлгөөнтуул ЗГХЭГ-ын референт гэсэн ийм ажлын хэсэг байна.

Хуулийн төсөл санаачлагчийн танилцуулга илтгэлээс асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Энэ маш зөв зүйтэй хууль орж ирж байгаа энийг дэмжиж байгаа юм. Сая энэ зүүн 3 аймагт бол энэ өвөл маш хүнд өвөл боллоо. Үнэхээр хүний хүчин зүйлээс давчихсан ийм нөхцөл байдал байна. Малчдын өмнө бол 4 асуудал тулгамдаж байна. Нэгд бол зээл, зээлийн хүүгийн асуудал. Энэ сэг зэмийн устгалын асуудал байна, малжуулах асуудал байна. Ер нь цаашидаа мал аж ахуйгаа ер нь яаж авч явах вэ гэсэн ийм л том сорилтын өмнө Монголын мал аж ахуй бэлчээрийн мал аж ахуй ирчхээд байна л даа. Энэ хуулиар бол би нэлээд олон зүйлүүд бас шийдэгдэж энэ малчид нэгдэж, нийлж хорших ийм зүйлүүдийг нэлээн дэмжиж өгч байгаа юм байна. Гол юм нь бол Зээлийн тэр батлан даалтын сан буюу одоо малчид зээл авахад тулгамддаг асуудлыг нэлээн сайн шийдэж өгөх юм байна.

Дээрээс нь малчны зээл гэж арилжааны банкнаас 20 гаруй хувьтай

авдаг энэ зээл маш бага хэмжээтэй зээл урт хугацаатай ирэх юм байна гэж ингээж ойлгож байгаа.

Тийм учраас энэ юуг дэмжиж байна? 2, 3 асуулт байна. Саяын миний хэлсэн асуудлуудаас гадна өнөөдөр малчдын ёстой нэг хоолой дээр нь тулчхаад байгаа асуудал бол энэ зээл, зээлийн хүүгийн асуудал байгаа юм аа. Үнэхээр одоо энэ хууль хэрэгжиж эхлэх, энийг хүлээхээс өмнө маргааш зээлээ төлөх нь битгий хэл маргааш юугаа идэх вэ гэж байгаа малчин өрх маш олон болчихоод байгаа. Ялангуяа энэ зүүн аймгуудаар бол.

Тийм учраас энэ зээл зээлийн хүүтэй холбоотой асуудал дээр Засгийн газар ямар зохицуулалт хийсэн бэ? Одоо энэ чинь 2 сард яригдсан цагаас хойш л малчин тухайн сумын арилжааны банкны ажилтан 2-ын хооронд тийм үл ойлголцлууд гарч байна шүү дээ. Төл гэдэг хойшлуулсан гэдэг. Тэгэхээр энэн дээр би нэг тодорхой асуулт авмаар байна.

Хоёрдугаарт энэ малчдын малыг индексжүүлсэн даатгалаар бас нэлээн хамруулсан. Энэний малын индексжүүлсэн даатгалын энэ асуудлууд ер нь энэ чинь улсын хэмжээнд 6 сая мал, 7 сая мал өшөө цаашаа өснө гэж байгаа. Энэ хариу арга хэмжээ тэр даатгалын эргэн төлөлт юмнудаа ер нь хэзээ хийхээр төлөвлөж байгаа вэ? Энэ бол малчдын өмнө бас нэлээн хүлээгдсэн ийм асуудал байна шүү гэдгийг бас хэлье. Тэр дагалдах хуулиуд дээр 2, 3 асуулт байна.

Нэгдүгээрт тэр 5 га гэдгийг ямар үндэслэлээр гаргаж ирсэн юм. 5 га-д одоо жишээ нь 20 малчин өрх нийлээд 5 га-д юм тариалаад олигтой юм авах уу? Га-аас хэчнээн ийм ургац авна гэж ингээж тооцсон юм бэ? Манай Цэнхэрмандал суман дээр бол 100 га-д 40 өрх, 2 тийм зуу, зуугаар нь 200 га-д тариалаад 45 мянгыг авсан ийм жишээ байгаа.

Тэгэхээр эндээс тэр малчид юу хэлж байна вэ гэвэл олуулаа ийм 100 га-д дээр тарьж байж ашиг гарах юм байна гэж байгаа байхгүй юу. Гэтэл одоо энэ чинь ямар 5 га дагалдах хууль дээр нь. 5 га хүртэл гэж байгаа байхгүй юу. Наадах чинь энэ сая 500 мянган км квадрат нутагтай ийм том газар нутагтай байж яагаад ийм га-д юм оруулж ирсэн юм.

Би 1 дүгээрт энийг тодруулъя гэж бодож байна.

Хоёрдугаарт энэ малчид нэгдэж нийлээд ингэхэд ер нь малчны хөдөлмөр хүнд. Энэ хөдөлмөрийг хялбаршуулахад энэ техник тоног төхөөрөмж гэдэг чинь туйлын чухал байна аа. Боогчоос авхуулаад л. Тэгээд л нэг жижиг ковч хүртэл л хэрэгтэй байдаг юм байна шүү дээ. Тэгээд энийг авахад энэ төрөл бүрийн баахан татварууд нэлээн өндөр хувийг нь аваад байдаг юм байна аа.

Тэгэхээр энэ гаалийн дагалдах хуулиуд дээр яг энэ малчин хоршоодууд нийлээд энэ оруулж ирэхэд, тоног төхөөрөмжүүд оруулж ирэхэд гаалийн татвараас нь хөнгөлөөд өгөх бололцоо байх уу? Ингэх юм бол энэ хоршоод зөвхөн одоо хүний хүчээр биш техникийн хүчээр бас хийх ийм бололцоонууд байна гэж. Тэгээд энэ болгоныг би яриад байгаа юм биш. Сая зүүн бүсээр ажиллахад энэ малчин олон нийт бол ийм зүйлүүд зохицуулалтуудыг төр хийж өгөөч гэдэг хүсэлтийг тавиад байгаа учраас би та бүхэнд уламжилж байгаа. Тэгээд хариултаа авъя. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Хариулт ажлын хэсгийн 1 дүгээр микрофон Амарбаясгалан сайд.

Д.Амарбаясгалан: Уур амьсгалын өөрчлөлтөөс уламжлалт мал аж ахуйд тулгарч байгаа асуудал гээд. Энэ бас өнөөдөр болчихож байгаа зүйл биш байгаад байгаа. Маш олон жилийн туршид уламжлалт мал аж ахуй цаг уурын энэ цаг агаарын энэ өөрчлөлтөөс

үүдэж өвөл нь зудтай, зун нь ган гачигтай мал нь авах ёстой тарга тэвээргээ авч чаддаггүй ийм нөхцөлд бол нэгэнт хүрсэн гэж ингэж үзэж байгаа. Бид бас энэ хуулийн төслийг боловсруулахдаа малчдын дунд социологийн судалгааг явуулж үзсэн. Тулгамдаж байгаа асуудал бол яалт ч байхгүй 71 хувьтайгаар энэ ган зудын асуудлыг бол хөндөж байгаа юм.

Тэгэхээр энэ тулгамдсан асуудлыг энэ цаг зудтай жилд бид энэ хуулийн төслийг өргөн барьж нэг мөсөн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авах нь зөв юм гэдэг байдлаар төслөө боловсруулсан. Идэрбат гишүүн 3 асуулт асуулаа.

Нэгдүгээрт ер нь энийг 3 ялгаж үзмээр байгаа юм.

Нэгдүгээрт өнөөдөр малчид зээлээ авчихсан байгаа хэрэглээнийхээ зээлийг эргэж төлж чадахгүй болчихлоо. Энэ дээр яах вэ гэдэг асуудал явсан. Засгийн газар сарын өмнө шийдвэр гаргаад Монголбанкаар дамжуулж арилжааны банкттай уулзаад үндсэндээ Хаан банк, Төрийн банкттай голчилж уулзалт хийсэн. Зээлийн эргэн төлөлтийн хугацааг нэг жилээр хойшлуулах энэ тохиролцоо шийдвэрт хүрсэн байгаа.

Хоёрдугаарт 1 жилээр хойшилсонтой холбогдуулаад хүү хуримтлагдана. Энэ хуримтлагдсан хүүг яах вэ гэдэг асуудал мөн адил яригдсан. Ингээд Засгийн газрын тогтоол батлагдаад яг өчигдрийн байдлаар буюу 4 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар албажиж эцэслэгдсэн. Энэ тогтоолоор яах вэ гэхээр хуримтлагдсан хүүгийн 6 хувийг малчид өөрсдөө үлдсэн хүүгийн зөрөөг Засгийн газар төсвийн мөнгөөр төлж барагдуулна гэдэг ийм шийдвэр гарсан байгаа. Ингээд албан ёсоор хэрэг бичээд эхэлсэн. Нэг дэх асуудал ингэж явж байна.

Хоёрт нь Идэрбат гишүүн асуугаагүй ч гэсэн малжуулах

хөтөлбөрийн асуудал бас яригдаж байгаа.

Цаашидаа малгүй болсон малаа 70-аас дээш хувиар алдсан малчид маань яах вэ гэдэг асуудал яригдаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээр тодорхой дүнтэй мөнгө бол байгаа. Үндсэндээ малгүй болсон иргэдийг малжуулах хөтөлбөрийг бол хийж авч явах боломжтой. Гэхдээ энэ мөнгөн дүн өмнөх жилүүдтэй адил нэг малчин өрхөд 5-аас 8 сая төгрөгийг урт хугацаанд хүүгүй болгох л боломж байгаа. Яг орчин нөхцөл дээрээ 5 сая төгрөгийг аваад малжаад малчид маань амьжиргаагаа залгуулж чадах уу үгүй юу гэдэг асуудал бас давхар гарч ирж байна. 5 сая төгрөгөөр хэдэн хонь, хэдэн үхэр, хэдэн ямаа аваад цаашаагаа амьдралаа залгуулах юм бэ гэдэг асуудал хөндөөд энэ өөрөө хүндрэлтэй зүйл гэдэг нь тодорхой болж байгаа юм.

Тийм учраас Засгийн газраас өнөөдрийн хуулийг өргөн барих энэ хууль батлагдсантай холбогдуулаад цаашидаа мал аж ахуйн салбарыг шинэ түвшинд гаргах хагас эрчимжсэн мал аж ахуйн салбарын шилжилтийг хийж эхлүүлэх ийм бодлогыг бол гаргаад ажиллаж байгаа гэдгийг бас хариулахыг хүсэж байна. Техник тоног төхөөрөмжийн хувьд ер нь цаашидаа малчид энэ малынхаа мал арчилгааныхаа технологийг дээшлүүлэх, ногоон тэжээл, өвсөө өөрсдөө тарьж ургуулдаг байх тэр боломж нөхцөлийг бүрдүүлэх үүднээс тодорхой бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Тэр хөтөлбөрийнхөө хүрээнд мэдээж энэ тоног төхөөрөмж технологийн шийдлүүдийг малчид хоршоондоо анхан шатны болон дунд шатын хоршоонд авч хэрэглэх нөхцөл боломж дээр нь бодлогын дэмжлэгийг үзүүлж ажиллах бүрэн боломж байгаа гэдгийг бас хэлье ээ.

Индексжүүлсэн даатгалын тухайд энд Сангийн яамнаас хүн байна уу

хэн хариулах вэ? Тулгаа дарга индексжүүлсэн даатгал.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 3 номер.

Тулга: Сайн байцаана уу? Сангийн яамны хэлтсийн дарга Тулга гишүүний асуултад хариулъя аа.

Малын индексжүүлсэн даатгалын эргэн төлөлт бол хагас жилийн мал тооллогын дараа хорогдлын хэмжээг тооцоод тухайн сумын хорогдлын хэмжээ 6 хувиас давсан тохиолдолд эргэн төлөлтийг эргээж олгодог байгаа.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Ч.Дондогмаа: ЗГХЭГ Дондогмаа. Идэрбат гишүүний газрын хуультай холбоотой асуултад хариулъя. Одоо газрын хуулиар бол иргэнд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх газрын зориулалттай болон шууд эзэмшүүлэх үү, давуу эрхээр эзэмшүүлэх үү, эс үгүй бол сонгон шалгаруулалт дуудлага худалдаагаар эзэмшүүлэх үү гэдэг зохицуулалтыг 29 дүгээр зүйлд заасан байгаа газрын хуулийн. Энд иргэнд бол 0.1 га-г үнэ төлбөргүй эзэмшүүлнэ. Газар тариалангийн буюу үр тарианы зориулалтаар 100 хүртэл га-г үнэ төлбөргүй эзэмшүүлэх зохицуулалтууд байгаа. Энэ зохицуулалтын хүрээнд бол анхан шатын хоршоо буюу 9-өөс дээш гишүүнтэй хоршоонд 5 өрх байна гэж тооцоод 5 га гэсэн зохицуулалтаар 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт нэмэлтээр оруулж ирж байгаа.

Энэнээс дээшээгээ 100 хүртэл га-аар үр тарианы зориулалтаар эзэмших эрх нь Газрын хуулийнхаа 29.3 дахь хэсэгт байгаа.

Ж.Батжаргал: Идэрбат гишүүн тодруулъя. Наадах чинь худлаа л юу байна л даа.

Ц.Идэрбат:

Малын индексжүүлсэн даатгалын асуудал дээр бас нэг жоохон тийм хурдавчлах түргэвчлэх юм байвал яг л одоо л хэрэгтэй байгаа юм даа. Тэгээд наадах чинь одоо явсаар байгаад нөгөө оны өмнө арай чамиа л очдог ийм л эд л дээ. Жоохон хурдавчилмаар. Газрын хууль дээр хэдүүлээ энэ чинь анхнаасаа томъёолол чинь ингээд 5 гэж орж ирээд энэ чигээрээ явчихвал дийлэхгүй байсаар байгаад л 5 гээд явчихна. Наадах чинь амьдрал дээр хөрсөн дээрээ буухгүй ээ. Одоо ямар кэйс яваад байна вэ гэвэл боломж байна уу гэвэл тэр газрыг заавал хэн нэгэнд өгөх гээд байх албагүй шүү дээ. Төрийн мэдэлдээ байг. Зүгээр тарих боломжийг нь нээж өгөөд хоршоодоо төр нь ашиглуулаад явдаг ийм хувилбар руу орвол. Тэгэхгүй бол 5, 3 хүн нь хоршоонд өгчихдөг. Тэр нь өөрийн юм шиг цааш нь зарж үрдэг ийм сөрөг юмнууд гараад байдаг юм аа.

Тэгэхээр газар бол төрийнхөө мэдэлд байдгаараа байгаад тухайн орон нутгийнхаа баг дээрээ байдаг юм уу, хаанаа байдаг юм тэр малчид нь таримаар байна. Нөгөө талдаа 5 гэдэг чинь хэтэрхий бага байна. Энэ боломжийг нээж өг.

Ж.Батжаргал: Санал байна уу? Бейсен гишүүн асуулт. Хэлэлцэх эсэх асуудал явж байгаа. Сая бол санал хэлчихлээ. Хэлэлцүүлгийн түвшинд анхаарна биз.

Б.Бейсен: Энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой малчдаас шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа. Яг цагаа олсон асуудал байна. Бид жилийн жилд ингээд л байнга зудын юм ярьж байх уу? Саяын зудын байдлыг харж байхад энэ урд энэ Дорнод, говийн аймгууд дээр чинь малын хашааны асуудал байна даа. Тийм сараалжин модтой хашааг чинь цасанд дарагдахгүй яадаг юм битүү хашаа барих тал дээр ер нь төсөл

хөтөлбөр энэ хуулийн төсөлд тусгах юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт тэжээлийн асуудал байна л даа. Жилийн жилд ингээд гуйлга гуйгаад энд тэндээс тэжээл гуйдаг. Тэжээлийн үйлдвэр байгуулах асуудал дээр дотооддоо бас боломжтой тариалах тал дээр. Энэ талаар ямар бодлого барьж байна? Тэр малчдын зээлийн асуудлыг ярьж байна. Түрүүн Идэрбат гишүүн ярьсан учраас тэрийг давхардуулаад ярихгүй байх бодолтой байна. Ийм уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой отрын бүсийн асуудал байна. Хил орчим тэгээд тусгай хамгаалалттай газрууд. Энийг харьяа аймгуудаас нь бас зөвшөөрөл авдаг. Зарим нь өгдөггүй тийм отрын бүсийн юун дээр.

Жишээлбэл Баян-Өлгий аймгийн Булган сумын малчид Хөх сэрхий нурууны тусгай хамгаалалттай газар руу очсон. Дунд гол гээд газар. Ховд аймгийн Засаг даргатай яриад, Ховд аймгийн Ховд сумын Засаг даргатай яриад яасан чинь Байгаль орчны яам нь аваачаад 3 сая төгрөгөөр торгосон. Өөрсдийгөө гэрчээр оруулахгүй шууд торгоод л дараа нь сая зудаар бүх малынхаа 60 хувь алдсан тийм улсууд байж байгаа. Засаг дарга ингээд Байгаль орчны яам хоорондын ийм асуудлаас жирийн иргэд хохирч байгаа асуудал байгаа. Энийг яаж шийдэх вэ? Энэ хуулийн төсөл дээрээ.

Нөгөө талаар зудын эрсдэлтэй холбоотой хамгийн хэцүү юм бол багийн эмийн сангийн асуудал байгаа. Эмийн алба үүсэж хөгжөөд 100 жил болж байхад багийн эмийн сан гэж байхгүй. 100 хэдэн километр газар яваад тэгээд эм хайгаад явдаг багийн эмчийн асуудал. Отрын бүсэд нүүдлийн эмч, эмийн сан ажиллуулах талаар энэ хуулийн төсөлд тусгасан уу. Энэ талаар асууя.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон Амарбаясгалан сайд.

Д.Амарбаясгалан: Малын хашаа хашааны стандартыг бол энэ хуулиар бол Хөдөө аж ахуйн яам стандартыг нь баталж өгөхөөр үндсэндээ бол тусгагдаж орж байна. Тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэл дээр Засгийн газар бодлого гаргаж ажиллана гэсэн ийм зорилтыг бол энэ хуулиар бас зааж оруулж байгаа. Гол агуулга энэ хуулийн үндсэн зорилго юу вэ гэхээр энэ мал аж ахуйн салбарыг тодорхой түвшинд либералчилж өгөх л бодлогыг барьж байгаа юм. Одоо төрөөс очиж хашааг нь барьж өгдөг, төрөөс очиж тэжээлийг нь тарьж өгдөг. Төрөөс очиж хуц ухныг нь аваачиж хээлтүүлэг хийж өгдөг ийм арга хэлбэрээр цаашидаа явах боломжгүй болж байгаа нь нэгэнт тодорхой болж байна.

Тэгэхээр энэ хууль батлагдсанаар малчид урт хугацааны хөнгөлөлттэй зээлийг авах боломж бүрдэнэ. Тэр зээлээр малчид нэгдэж, хоршиж хамт хамтдаа өртөг шингээх нэмүү өртөг шингээх боломжтой аж ахуйг байгуулах нөхцөлийг нь гаргаж өгч байгаа юм. Ер нь үндсэндээ малчдын хувьд бэлчээрийн хомсдол бэлчээрийн хомсдолыг бий болгож байгаа олон тооны малтай байх байгаа олон тооны мал нь чанаргүй байгаа зэрэг нь өөрөө амьдралын баталгаажих түвшинээс доогуур орлоготой иргэн болгож хувиргаж байгаа юм.

Өнөөдөр малчдын дундаж сарын орлого сая 500 мянган төгрөг, сарынх нь зардал нь 2 сая 100 мянган төгрөг. Яг эндээс ингээд дүгнэхээр малчид сар болгон 600 мянган төгрөгийн алдагдалтай амьдарч байгаа ийм дүр зурагтай байна. Тэгэхээр энийг нэг мөр засах үүднээс өнөөдрийн энэ хуулийн зохицуулалтаар малчид хөнгөлөлттэй зээлийг урт хугацаанд аваад анхан шатдаа өртөг шингээх боломжийг бий болгож байгаа юм. Анхан шатдаа үйлдвэрийн аргаар малаа нядалдаг больё. Үйлдвэрийн аргаар нядалсан малын арьс шир, түүхий эд, зах зээлийн зарчмаар үнэд хүргэх тэр боломж

нөхцөлийг нь бүрдүүлж өгье. Анхан шатны арьс шир боловсруулалт хийдэг тордолт хийдэг тэр цехээ байгуулах боломжийг нь олгож өгье.

Ногоон тэжээл өвсөө өөрсдөө сум орон нутагтаа тарьдаг байх боломжийг нь гаргаж өгье гэж байгаа юм. Идэрбат гишүүн түрүүн асууж байна лээ 5 га газар гээд 2 ялгаатай зүйл байгаа юм. Энэ 5 га газрыг олгох гэж зохицуулалт хийж орж ирж байгаа зүйл нь хоршоо байгуулах бодлогыг дэмжиж байгаа. Хоршоонд өгч байгаа хөрөнгө хэлбэрээр өгч байгаа одоо нэг талын урамшуулал гэдэг талаасаа харж болно эзэмшүүлэхээр.

Харин өөрсдөө өвс тэжээлээ бэлтгэх, ногоон тэжээлээ тарих зориулалттай тариалангийн талбайг сумтайгаа хоршоо харилцаж хамтарч ажиллах замаар өвс тэжээлээ тарьж бэлтгэх боломж өнөөдөр хуулиар нээлттэй байгаа. Гагцхүү энэ боломжийг хоршоо анхан шатны болон дунд шатын хоршоо болж чадсанаараа хэрэгжүүлэх боломж нь нээгдэх юм гэж бидний зүгээс үзэж оруулж ирж байна аа.

Тэр Ховд аймагт өвөлжсөн.

Ж.Батжаргал: Бейсен гишүүд тод нэмж тодруулъя.

Б.Бейсен: Тэр сая хашаа байшин ингээд л өөрсдөө асуудал гээд тэгж байна л даа. Жилийн жилд энд маш их хэмжээний Засгийн газраас Онцгой комиссоос аймгаасаа л их төсөв гарч байгаа шүү дээ. Ядахдаа хөнгөлөлттэй зээлийг энэ хуулийн төсөлдөө тусгаад хашааг нь битүүлээд яачихвал бас цасан шуурга энэ тэрд нь битүү хашигддаг. Дараа нь 7 хоног тасралтгүй шуурна гэж байхгүй шүү дээ. Нэг, хоёр хоногтоо тэжээл нь хангалттай байвал дотроо яагаад л тэгээд. Энэ асуудлыг бас хөтөлбөрт тусгавал зүгээр байна.

Саяын Ховд аймгийн асуудал дээр байна шүү дээ. Өлгий энэ хил орчмын бүс

дээр отрын бүс их байгаа. Энийг шийдэж өгөхгүй бол бас энд тэндээсээ яам тусгай хамгаалалттай газрууд зарим нь хоорондоо таарахгүй байсан ийм асуудал үүсэж байгаа. Нөгөө талаар тэр Баяннуур сумын нөгөө тэр УЦС 500 айлын хадлангийн талбай байгаа. Энийг яаж шийдэх вэ жишээлбэл энд отрын бүс дээр нэлээн хүндрэлтэй асуудал гарах юм шиг байна.

Ж.Батжаргал: Хариулъя УЦС-тай холбоотой хэн хариулах юм?

Д.Амарбаясгалан: Эрдэнэбүрэн дээр мэдээж УЦС барих төсөл хэрэгжиж байгаатай холбоотойгоор газар нутгийн бүсийг тогтоогоод тухайн бүс нутагт хамрагдсан 3 аймгийн малчин өрхийн нөхөн олговрын асуудлыг бүрэн шийдвэрлээд энэ төсөл энэ оноос эхлээд хэрэгжиж эхэлж байгаа. Тэнд нутаглаж байсан малчдад бол мэдээж газар олгох нөхөн олговрыг нь олгох энэ ажлыг бол Эрчим хүчний яам, аймаг орон нутаг бол хамтраад зохион байгуулаад явж байгаа. Одоогийн байдлаар Засгийн газар дээр асуудал шийдвэрлэгдээгүй байна гэдэг гомдол ирээгүй байна.

Ж.Батжаргал: Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Уламжлалт мал аж ахуйд тулгамдсан, тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах гэж байгаа юм. Бууруулах тухай хуулийн төсөл гээд ингээд орж ирж байна аа. Хуулийн төслийг бол дэмжинэ ээ. Дэмжих ёстой юм. Ер нь бол саяын энэ өвөл хаврын хүндрэлтэй нөхцөл байдал чинь бол Монголчуудад нэг зүйлийг бодогдуулаа.

Мал аж ахуй гэсэн энэ салбараа бид нар үндсэндээ хаячихсан байхгүй юу. Тааваараа явж байгаа. Би заримдаа бол зэрлэг мал аж ахуй ч гэж хэлчхэж байгаа юм. Тэгэхээр ерөөсөө МАА гэдэг бол мал бол хувийн өмч гэдэг утгаар нь бол бид нар нэг хэсэг бол ингээд хаяад явчихлаа шүү

дээ. Гэтэл хувийн өмч биш ээ. Хувийн өмч биш гэж хувийн өмч. Гэхдээ энэ чинь цаад утгаараа бол эрх ашгийн хувьд бол Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамж гээд бүр томоороо бид нар харах ёстой зүйл байхгүй юу даа. Тэгэхээр энд одоо уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой дасан зохицсон ийм МАА, хагас фермер хагас суурин маллагаатай гэх юм уу ийм аж ахуй болох хэмжээнд нь дэмжлэг үзүүлэхээр тэгээд тэр дотроо бол хоршоог бас дэмжье. Хоршоолсон хэлбэрээр оруулья гэдэг нь бол бас зөв зүйтэй байх гэж үзэж байгаа юм. Энэ танилцуулгад хэллээ. Ногоон тэжээл тариалахад боломжтой болно оо гэж. Малчид ногоон тэжээл тарих бололцоотой болно.

Тэгээд энэ 5 га-тай холбоотой асуудал яригдаж байна. Миний бие болон бусад нэг хэдэн гишүүдээ бид нар хамтраад хууль өргөн барьсан. Яг энэ газрын тухай энэ хуульд та бүхний өргөн барьсан энэ хуульд чинь хуультай адилхан ийм хууль орж ирсэн. Энэ нь болохоор малчдад өвөлжөө хаваржааных нь хөл дээр гэж байгаа шүү. Ер нь өвөлжөө хаваржаан дээрээ нэг га хүртэлх газар ногоон тэжээл тарих, жимс жимсгэнэ тарих гээд ингээд хүнсний ногоо тариалах гээд ингээд бүхэлд нь оруулаад ирж байгаа юм том утгаар нь.

Тэгэхээр энэнтэй яаж бас уялдах байдлаар харж байна аа? Яагаад гэхээр ер нь бол энэ хуульд зааснаар бол Газрын тухай хуульд тэр тухайн газар нутгийн Засаг дарга нь ингээд заагаад өгчхөж байгаа шүү дээ. Одоо манайх бол жишээ нь сумандаа бол энэ хавьцаа л газар тариалан эрхэлж болно. Энэ шигээ та нар газар ав гээд тэнд нь нэг га байсан бол 5 га гэххэж байгаа юм. Гэтэл бид нар хагас суурин маллагаатай ийм аж ахуй руу орно гэж байгаа бол үнэхээр бид нарын тэр хагас суурин маллагаатай аж ахуй чинь хаана бий болох юм бэ?

Өвөлжөө хаваржааны түшиглэсэн хагас суурин маллагаатай

ийм л аж ахуй бид нар бий болох гээд байгаа шүү дээ. Малчин өрх гэдэг бол яваандаа бол аж ахуй болж хувирах гээд байгаа юм. Аж ахуй болж хувирах гээд. Тэр аж ахуй хаана төвлөрөх вэ гэхээр өвөлжөө хаваржаан дээрээ төвлөрч таарна.

Тэгэхээр өвөлжөө хаваржаан дээрээ зүгээр одоо бид нарын, өнөөдрийн нөхцөл байдал амьдрал дээр харагдаж байгаагаараа бол нөгөө бууцаа асгачихсан, хогоо хаячихсан, нэг тугалын хашаа барьчихсан тэр хашаа байшингийнхаа хороо саравчныхаа ар талд байж байгаа нөгөө шарилжинд идэгдчихсэн байгаа газраа л бид нар янзлаад тохижуулаад тэнд нэг га газар дээр ногоон тэжээл тарих бололцоог л хангаад өгчхөж байгаа байхгүй юу. Энэ нь өөрөө цаашилаад ямар ач холбогдолтой гэж бид хараад байна гэхээр суурин малгай бий болох тэнд нь тогтвор суурьшилтай цааш цаашидаа бол мэдээж бид нар олон өвөлжөө, хаваржаа аваад байх газар ч алга. Нутаг дэвсгэр ч хэцүү болж байна шүү дээ.

Тэгэхээр яг тэндээ суурьших ийм боломж бололцоог нь бол жишээ нь энэ дээр олгоод байгаа юм аа. Тэгэхээр энэтэй та бүхэн яаж харж байна. Ер нь бол уялдуулаад өвөлжөө хаваржаатай байх тэр нөгөө нэг хагас суурин малгайтай байх руу нь ингээд орох боломж бололцоо нь яаж харагдаж байна гэж.

Хоёрдугаарт тоног төхөөрөмжийн дэмжлэг гээд сая сая Идэрбат гишүүн бас хэлчихлээ. Ер нь бол шинэ хөдөө гэдэг хөтөлбөр нэлээдгүй олон аймгуудаар 10 гаран аймгуудаар хэрэгжээд явж байгаа. Энэ хөтөлбөрийн ганц боломж бололцоо нь бол аж ахуйн нэгж буюу иргэд авч чадахгүй байгаа тоног төхөөрөмжийг нь бид нар эндээс шинэ хөдөөгөөрөө бол олгох түрээсийн байдлаар олгох ингээд урт хугацаанд нь боломж бололцоог нь олгоод аж ахуйд нь дэмжлэг үзүүлэх ийм зорилгоор яваад

байгаа хөтөлбөр шүү дээ. Тэгээд саяхан бол Солонгост явж байгаад бас яг ийм аж ахуйтай бол орж танилцсан. Ерөөсөө тэр том том ангар дотор бол дүүрэн техник. Ерөөсөө тэр Солонгосынхон өөрсдийнхөө тариаланч жимс ногоо тарьдаг хүмүүстээ түрээсээр өгчхөж байгаа байхгүй юу даа. Манайхан яаж байна гэхээр хуруу хумсаа хугалж хугалж байгаад л нэг ганц трактор аваад л тэгээд л газраараа.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Д.Амарбаясгалан: Ер нь энэ хуулийн төслийн гол үзэл баримтлалыг бол малчид амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор малынхаа таваарлаг чанарыг дэмжих, тэгэхийн тулд өвс, тэжээлээ өөрсдөө тарьдаг байх, малаас гарч байгаа түүхий эдэд анхан шатанд нь өртөг шингээдэг болох боломжийг олгох гэдэг асуудлууд үндсэндээ гол зорилго болоод явж байгаа юм. Малчны хууль дээр жишээ нь таны саяын ярьсан нэг га газрыг өрх тус бүрд өмчлүүлж ногоон тэжээл тарих гэж байгаа. Яг амьдрал дээр малчидтай уулзаад судалгаа хийгээд үзэхээр яг энэ өрх тус бүр нэг га гэдэг дээр төдийлөн өндөр дэмжлэг өгөхгүй байгаад байгаа юм. Яагаад гэхээр нэг га болгон дээр ногоон тэжээл тарих тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалт тэгээд ногоон тэжээлээ тарьсны дараа хураах, савлах, баглах гээд олон зүйл дээр бол тодорхой хүндрэлүүд гарах эрсдэлтэй гэж малчид бол үзээд байгаа юм.

Малчид харин юуг дэмжээд байна вэ гэхээр сумынхаа түвшинд, багийнхаа төв түвшинд нийлээд 100, 200 га талбай дээр сум орон нутгийнхаа хэрэгцээг хангаж чадахуйц өвс тэжээлээ бэлддэг болох энэ хүсэлтийг тавьж байна. Энэ жилийн зуднаар нэг зүйл маш тодорхой болчхож байгаа шүү дээ. Ялангуяа зүүн аймагт тарьж ургуулсан өвсийг нөөцлөөд баруун аймгийн малд өгөхөөр тэжээл уургаа хангалттай хэмжээнд авч чадахгүй байна аа. Хөрс газар зүйн

байрилын онцлогоосоо хамаараад яг хоол тэжээл нь зөв тохирохгүй байна гэдэг асуудал хөндөгдөж байна. Говийн мал таана, хөмүүл идэж тарга тэвээргээ авдаг. Тэгвэл яг зүүн аймагт ургасан тэр өвс тэжээлээр тэжээж бордоно гэдэг ойлголт бол үндсэндээ байхгүй болчхож байна.

Тэгэхээр энэ хуулиар энэ хоршоонд нэгдсэний урамшуулал болгож тэр 5 га-г эзэмшүүлэх хэлбэрээр өгнө. Хоршоо цаашидаа сум орон нутгийнхаа хэмжээнд 200, 300 гад тариалалт эрхлэх боломжийг бий болгож өгч байгаа юм. Гэхдээ энэ нь өөрөө дан ганц зөвхөн хоршоо байгуулагдсанаар биш магадгүй иргэдийн малчдын хэрэгцээний ногоон тэжээлийг тарих зорилготой хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжтэй хоршоо хүртэл байгуулагдах боломжийг энэ хуулиар гаргаад өгчхөж байгаа юм.

Жишээлбэл малын эмч нар хүртэл бас нийлээд нэгдээд 1 хоршоо байгуулаад аймаг, сум, бүс нутгийн хэмжээнд малыг эрүүлжүүлэх бодлого хөтөлбөрийг хувийн хэвшлийн хүчин чадлаар аваад явах боломжтой л гэдэг агуулгаар нь энэ өнөөдрийн хуулийн төслийг оруулж ирж байгаа. Мэдээж яг малчдад тулгамдаж байгаа хашаа хорооны сайжруулах, малын өвчин эмгэгийг арилгах өвс тэжээлийн бэлтгэлийг хангах гэдэг асуудал дээр төр бодлогын дэмжлэг үзүүлж байх ёстой. Гэхдээ энэ бодлогынхоо дэмжлэгийг бид үзүүлж байгаа нэрээр хотонд нь өөрсдийн бодлогыг шууд тулгадаг энэ байдлаас татгалзаж харин тэр бодлогоо хэрэгжүүлэх эдийн засгийнх нь хөшүүрэг боломж зээл олголтынх нь асуудал дээр хөшүүрэг нь больё оо гэдэг ийм зорилгоор өнөөдрийн энэ хуулийн төсөл боловсруулагдаж орж ирж байгаа.

Ж.Батжаргал: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгөөрэй.

Ж.Бат-Эрдэнэ: Амарбаясгалан дарга аа бид нар тэр 250 га, 200 га-аар малчдад өгч хоршоо болгуулаад 20 гэр бүл эд нар ороод ингээд явсан. Ийм нөхцөл байдлаар бид нар хийгээд туршаад үзчихсэн. Одоо яг тэр тэрийг хийж байгаа жишээ нь Булган аймаг дээр бид нар шинэ хөдөөгийн хүрээнд бол 20 өрх нийлээд ингээд хийгээд явж байгаа өнөөдрийг хүртэл байгаа.

Тэгэхээр энд яаж байна гээд тэгэхээр мэдээж тэр 100 га эд нарт чинь тэр болгон олдохгүй суманд. Тэрэнд олдож байгаа нь хэн хөдөлгөөнтэй байна, хэн зальтай, хэн боломжтой нь тийшээгээ орчихдог цаана нь иргэд үлдчихээд байгаа юм. Иргэд үлдчихээд байгаа юм. Тэгэхээр тэр иргэдэд тус дэм болгохын тулд өөрсдийнхөө хашааныхаа өөрсдийнхөө боломж бололцоогоороо тэгээд хаддаг ч юм уу яадаг ч юм ийм бололцоог нь хангачихъя гэж байгаа байхгүй юу. Маш олон иргэд нь цаана нь үлдчих гээд байгаа юм л даа. Хамгийн гол нь.

Хоёрдугаарт тоног төхөөрөмжийн дэмжлэг бол зайлиггүй байх хэрэгтэй болчихоод байгаа юм. Сая Идэрбат гишүүн хүртэл хэллээ шүү дээ. Тэгээд миний тэр яриад байгаа нь бол Солонгост бол жишээ нь тоног төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлдэг тосгон болгонд нь.

Ж.Батжаргал: Хариулчихъя. Ажлын хэсгийн нэг.

Д.Амарбаясгалан: Мэдээж энэ хууль эрх зүйнхээ орчны хүрээнд яг малчид одоо эзэмших байдлаар газар авах боломж хаагдмал байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энийг мэдээж тэр малчны хуулиар зохицуулалт хийх гээд зориуд төсөл дээр боловсруулагдаад явж байгаа гэж бид ойлгож байгаа юм. Одоо энэ өнөөдрийн хуулиар үндсэндээ нэгдсэн тохиолдолд 5 хүртэл га газрыг олгох боломжийг эзэмших хэлбэрээр олгох боломжийг нээхээр орж ирж байгаа.

Магадгүй Улсын Их Хурал дээр хэлэлцэгдэх явцад малчныхаа хуультай нийцүүлээд тодорхой энэ өөрчлөлтүүдийг хийгээд явах боломж нь бол нээлттэй байгаа гэж ингэж бол харж байгаа. Ер нь энэ өвс тэжээлийн хэрэгцээ жишээ нь Бат-Эрдэнэ гишүүн ээ ийм байгаа шүү дээ. Нэг аймгийн нийт малчдын нөөцийг бэлтгэхэд хэчнээн га газар усалгаатай ногоон тэжээл тарихад тэрийг хангах вэ гэдгийг л бид эдийн засгийнх нь үр өгөөж талаас нь л харах ёстой. Айл болгон тусдаа тарьснаар ашигтай гэж хэлж болохгүй. Тэр бүс нутагт нь ногоон тэжээлийг ашиг нөгөө амт шимттэй, уурагтай тэр ногоон тэжээлийг нь тариад элдэв янзын тээврийн зардал нэмүү өртгүүд шингээхгүйгээр олгоно оо гэдэг нь өөрөө малчдад илүү ач тустай зүйл.

Тэгэхгүй болохоор зүүн аймгаас ачиж очиж байгаа нэг боодол өвс баруун аймагт 20 мянган төгрөг болоод очиж байгааг чинь л 1 дүгээрт худалдаж авч чадахгүй байна.

Хоёрдугаарт уураг тэжээлээ хангалттай авч чадахгүй байгаа л асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг зөвхөн газар орон нутаг дээр нь тарих боломжийг олгож өгнө гэдэг нь гол бодлого байх ёстой? Түүнээс айл болгон тарьснаараа хямдхан байна гэдэг ойлголт байхгүй. Айл болгон тарьснаараа ач холбогдолтой гэдэг ойлголт бас учир дутагдалтай байна гэж үзэж байгаа. Энийг ганц төсөл боловсруулсан ажлын хэсэг хэлж байгаа юм биш. Энийг малчдын дунд хийсэн социологийн судалгааг үндэслэж бид бас дүгнэлт хийж ийм шийдвэрийг гаргаж төсөл боловсруулж оруулж ирсэн.

Тоног төхөөрөмжийн тухайд хэдэн янзын хэлбэр байна л даа. Мэдээж яг төр засгийн зүгээс яг таны хэлж байгаа загвараар сум болгон тоног төхөөрөмжтэй болоод ажиллах боломж.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 3.

С.Тулга: Гишүүний асуултад нэмж хариулъя.

2021 оны 4 сарын 23-ны өдөр импортоор оруулж байгаа болон дотоодод борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн болон шувуун аж ахуйн техник тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг 2025 оны 1 сарын 1 хүртэл нэмэгдсэн өртгийн албан татвараас ингээд 4 жилийн хугацаанд чөлөөлчихсөн хууль байгаа.

Ж.Батжаргал: Ганболд гишүүн асуулт асууя.

Г.Ганболд: Хуулийн төслийг сая л харлаа л даа. Тэгээд хуулийн төсөл боловсруулсныг харахад бол ингээд л Улсын Их Хурлын бүрэн эрх гэгчээд нэг хэдэн үүрэг биччихсэн байгаа. Малчин орон нутагтаа тогтвор суурьшилтай, ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нь бид нарын үүрэг болохоос эрх биш шүү дээ. Эрхүүдийг нь харах хэрэгтэй. Энэ дээр Засгийн газрын эрх дээр бол энэ өөрөө би бас Улсын Их Хурлын ганц онцгой бүрэн эрх бол төсөв л дөө. Тэгэхээр энэ дээр бол энэ 6.1.9 дээр батлагдсан төсвийн маань ингээд төсөв хооронд төсвийн ерөнхийлөн захирагч хооронд тэгээд бүүр хөрөнгийн болон урсгал зардал хооронд нь ингээд зохицуулалт хийх эрхийг авчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр зэрэг ингээд нөгөө тэгэхээр чинь энэ чинь бүүр төсвийн хуулиасаа ч давсан хууль болох нь л дээ. Энэ цаашидаа бол ингээд энийг далимдуулаад зөвхөн энэ жилийн хувьд биш ингээд жил болгон энэ чинь аль нэгэн аймагт ингээд нэг малын эрсдэл гарна шүү дээ. Тэгэхээр энүүгээр энэ заалтаар ингээд л төсөв дотор нь Их Хурал нэг баталсан нэртэй дараа нь ингээд төсөв дотор нь ингээд бүүр Ерөнхийлөн захирагч дотроо бол ингээд яах вэ болох юм. Одоо энэ чинь бүүр ингээд

Ерөнхийлөн захирагчид яамдын төсвүүдийг хооронд нь ингээд гүйлгэх нь байна шүү дээ дарга аа.

Тэгэхээр зэрэг энэ дээр одоо гол хуулийн гол зорилго нь л энэ юм болов уу л гэж би зүгээр харлаа л даа. Тэгээд ядаж тэгвэл энийг ингэж оруулах гэж байгаа бол орон нутгийн эрх дээр нь Засаг Засаг даргын эрх дээр тэрийгээ бас эсвэл оруулчихвал яадаг юм. Ядаж нэг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч дотроо нэг гүйлгээд явчих тэр эрхийг нь өгөөгүй хэрнээ одоо арга хэмжээ авч зохицуулалт хийгдсэн байгаа юм. Тэгээд тэр хүнд чинь тэр эрхийг нь бас тавьж өгмөөр байх юм. Орон нутаг руу. Тэгээд гол нь би эндээс ерөөсөө ингээд малчдын энэ эрх үүргийг энэ ажлын хэсгийнхэн сайн хараарай. Малчны эрх үүрэг гэгчээд л тэгээд л үүрэг нь аль нь юм, эрх нь аль нь юм. Энэ чинь шал өөр 2 ойлголт шүү дээ. Тэгээд би энэ дээр зүгээр яах вэ нэг л юм ярих гээд байгаа юм. Энэ Зээлийн батлан даалтын сан ингэх юм бол дампуурна шүү дээ. Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэр ер нь хэр юм байгаа юм? Одоо ингээд эрсдэлд орсон малчдын зээлийг 100 хувь зээлийн батлан даалтын сан хариуцах юм бол иргэд төлөгдөнө гэсэн ойлголт бараг байхгүй болж байгаа юм. Энэ чинь бол тэгээд энэ сангийн чинь эх үүсвэр хэр юм байгаа юм? Энэ тэгээд тэр чигээрээ шууд дампуурна. Тэгээд бид нар байна шүү дээ ингээд зөвхөн малын л юм яриад байх юм. Нөгөө малын уламжлалт малаа нөгөө адгуулж байгаа малчдадаа бид нар энэ хуульд оруулж өгмөөр байна л даа.

Бид нар ингээд гамшиг эрсдэл гээд л ингээд л гал онцгойгийхон нэг онцгой байдлын аврагч нар нас барахаар зэрэг байр янз бүрийн юм өгөөд байдаг. Гэтэл одоо ингээд өнгөрсөн жил Төв аймагт 4 идэрхэн малчин эмэгтэй малынхаа араас явж байгаад цасан иуурганд нас барчхаж байгаа байхгүй юу. Тэр бол Үндсэн хуулиараа мал сүрэг бол төрийн өмч. Тэр төрийн өмчийг хамгаалах гэж явж байгаад эрсдэлд орчхож байгаа хүн

байхгүй юу. Төрийн өмчийг хамгаалах гэж явж байгаад эрсдэлд орж байгаа юм.

Тэгэхээр энэ яг малаа хариулж яваад тэгээд яг энэ эрсдэлд орж байгаа тэр малчдад нөхөн төлбөрийн асуудал энэ тэрийг бас энэ хуулиар зохицуулаад ингээд явах юм бол их зүгээр юм шиг байх юм. Тэгэхээр энэ дээр бас ямар байр суурьтай байгаа вэ гэдгийг асууя. Тэгээд түүрүүний Идэрбат гишүүний хэлсэн тэр газрын асуудал бол уг нь хоршоо болгоод явбал жаахан яг даацтай юм гэдэг нь амьдрал дээр 5 га дээр үр дүн гарахгүй ээ. Яах вэ 50, 100 га дээр бол үр дүн гараад яг амжилттай явж байгаа хоршоонууд их олон байна аа.

Тэгээд нөгөөдүүл чинь нөгөө жаахан ахиу болоод тавхан айлтай хоршоо гэдэг бол бас байхгүй дээ бараг. Бүүр олон сумаараа ч хоршоо болчихсон газрууд байна. Олон өрхтэй хоршоон дээр бол ингээд нэгэнт хөдөлмөрийг нь хоршиулах гэж байгаа бол газрын асуудал байгаад байгаа байхгүй юу. Газар хүссэн хүмүүс зөндөө байна.

Тэгэхээр тэрийг нь 5 га гэдгийг нэг жоохон нэмэгдүүлээд өгчихвөл бүгдээрээ ингээд эрсдэлгүй нэг.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн нэг.

Д.Амарбаясгалан: Төсвийн зохицуулалт хийх боломжийг зөвхөн 24 оноор хязгаарлаж байгаа. Уур амьсгалын өөрчлөлтөөс уламжлалт мал аж ахуйд тулгамдсан асуудал өөрөө гамшигийн хэмжээнд хүрч байгаа. Гамшигийн хэмжээнд хүрсэн учраас энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор өнөөдрийн энэ хуулийг боловсруулж оруулж ирсэн зорилго. Тэгэхээр энэ ондоо хэрэгжээд зохицуулалтыг хөдөө аж ахуйн сайд Сангийн сайд нарын төсөв батлагдчихсан багцынхаа хүрээнд зохицуулалт хийх боломжийг олгож өгч байгаа юм. Нэг ёсондоо Зээлийн батлан даалтын сангийн тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлд.

Тэгээд зээлийн батлан даалтын санг дампуурахад нэг их санаа зоволтгүй байх гэж бодож байна.

Ялангуяа бид малчдад өнөөдөр асуудал ямар хүнд тулгамдсан нөхцөлд оччихсон байна. Мал аж ахуйн салбарыг бид цаашидаа тогтвортой, үр дүнтэй, үр ашигтай байх энэ боломж нөхцөлийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлж байгаа учраас энэ дээр бол эрсдэлийг мэдээж тооцсон. Арилжааны банкнаас авч байгаа зээлийн 80-аас 100 хувь хүртэл Зээлийн батлан даалтын сан батлан даалт гаргахаар болж байгаа юм. 80 хувь гэдэг нь хамгийн их хэмжээний зээл буюу 50 хүртэл сая төгрөгийн зээл. Нэг малчин өрх хоршооны гишүүн болсныхоо үндсэн дээр авах зээлд өгөх баталгаа. Тэр зээлийг малчин шууд аваад өөрийнхөө хэрэглээнд зориулах гэж байгаа зүйл биш. Энэ зээлийг авснаараа шинээр бий болох аж ахуйд оруулж байгаа хөрөнгө оруулалт хэлбэр рүү нь илүү анхаарна гэсэн үг.

Нэг ёсондоо бол шинээр бизнес бий болж байгаа. Тэрэнд нь тэр нь өөрөө энэ зээлийнх нь үндсэн барьцаа болоод явах нөхцөлтэй. Зээлийн батлан даалтын сан өнгөрсөн жилүүдэд тодорхой зээлүүдэд батлан даалт гаргаж ажиллаж байсан туршилага нь бас байна. Дунджаар эрсдэлийг бол 6-аас 7 хувьд бол тооцдог. Засгийн газар ч гэсэн бас энэ эрсдэлийг 6-аас 7 хувьд нь тооцож байна. Энэ эрсдэл энэнээс илүү гарсан тохиолдолд хувийн даатгалын компаниудыг оруулж ирж ажиллуулах ийм байдлаар бид бол санал солилцож ажиллаад явж байгаа юм. Нэг ёсондоо 6-аас 7 хувиас давсан эрсдэлийг хувийн даатгалын компаниудад даатгуулах байдлаар зохицуулалтыг хийнэ ээ. Гол зорилгыг би бас дахиад хэлье. Мэдээж мал аж ахуйн салбар стратегийн ач холбогдолтой чухал салбар аа.

Энэ салбарт өсөж дэвжих тэр боломжийг төдийгөөс өдий хүртэл сүүлийн 30 жил хангалттай хэмжээнд олгож чадаагүй байна. Малаа

эрүүлжүүлэх, бүртгэлжүүлэх, өвс тэжээлээр хангах гээд шат шатын арга хэмжээнд авсан. Гэхдээ өнөөдөр малчид маань бас л орлого багатай. Сард сая 500 мянган төгрөгийн дундаж орлоготой. 2 сая 100 мянган төгрөгийн дундаж зардалтай болчихсон байгаа нөхцөл нь авч хэрэгжүүлсэн бодлогууд мэдээж тодорхой хэмжээнд үр дүнгээ өгсөн ч асуудлыг бүрэн шийдэж чадаагүй байна аа.

Тэгэхээр энэ салбарыг хөл дээр нь босгох цаашидаа ДНБ-д үзүүлдэг нөлөөлөл өнөөдөр 10.5 хувьтай бол энийг 30 хувьд хүргэх энэ бий болж байгаа баялгаас ДНБ-ийг бүрдүүлдэг төсвийн орлого талдаа.

Ж.Батжаргал: Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Энэ хуулийн төслийг дэмжинэ. Энэ зайлшгүй орж ирэх ёстой ийм асуудал байгаа. Тэгэхээр дэмжинэ. Тэгэхээр нэг тодруулах хэдэн зүйлүүд байна аа. Энэ Малчин өрхүүдийн холбооны эрх зүйн байдлын тухай гээд хууль бид хэд сая бас ажлын хэсэг баталчихлаа.

Дээрээс нь энэ өнөөдрийн энэ хууль уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс гээд ингээд нэг харахаар яг нэг 1 жилийн энэ жилдээ төсвийн жилдээ багтаах ч юм шиг. Тэгээд нөгөө хууль нь ингээд удаан хугацаанд явахаар ч юм шиг. Тэгэхээр хоршоо холбоо гээд үг нь ч гэсэн ойрхон юм. Тэгэхээр энэ дээр ер нь юуны хувьд Засгийн газраас яг яаж уялдуулах юм бэ? Энэ 2-ыг. Энэ дээр нэг хариулт авчихмаар байна.

Хоёрдугаарт энэ хоршооны асуудал гээд гарч байна л даа. Тэгэхээр бид нар бас энэ салбар дээр ингээд явж байгаад хоршоон дээр аваад явах боловсон хүчний асуудал дээр нь ямар судалгаа байна аа. Хоршоо даргалаад явчих тэр хоршооныхоо цаашидаа энэ

удаан хугацаанд ажиллаад явах, энэ дарга хийх нягтлан энэ тэр гээд л энэ чинь хуулийн этгээд юм чинь ийм санхүүгийн хүн ингээд л хэрэгцээ болоод явчихна. Тэгэхээр энэ асуудал дээр нь ямар судалгаа тооцоо байна гэдгийг асууя.

Амарбаясгалан даргын үгнээс 5-аас 8 сая, 20-оос 50 сая хоршооны гишүүнд ингээд зээлүүд өгөх гээд энэ санхүүгийн асуудлууд нэлээн яригдаж байна. Тэгэхээр энэ дээр мэдээж мөнгөгүйгээр явах асуудал байхгүй. Тэгэхээр энэ дээр ер нь нийтдээ улсын хэмжээнд хэдий хэр хэмжээний мөнгө гэж харж байгаа юм бэ? Энэ одоо ингээд миний бас нэлээн их хэмжээний мөнгө л орохоор харагдаад байгаа юм. Тэгэхээр энийг тооцоолсон юм байгаа юу? Яг 5-аас 8 саяараа хэдэн төгрөг юм өөр энэ 20-оос 50 саяын зээл гээд тэгээд энэний тооцоог нэг асуучихъя. Сангийн яамныхан байгаа юм чинь. Тэгээд энэ дээр нөгөө зээлийг малчид авахгүй. Хоршоонд нь өгнө өө гээд тэгж байна.

Тэгэхээр нөгөө хоршооны дарга удирдлагууд тооцоогүйгээр ямар нэгэн байдлаар энэ их хөрөнгийг удирдаж байгаад эрсдэл учруулсан тохиолдолд эргэн төлөлтийн асуудал нь малчдын нуруун дээр бууна л даа. Энэ чинь өөрөө зээл. Тэгэхээр энэ асуудал дээр бас бид нар нэлээн тийм нухацтай хандмаар байна л гэж ингэж харагдаад байгаа юм. Малжуулах хөтөлбөрийг хагас жилийн тоо Хөдөө аж ахуйн яам энийг хариулчих. Хагас жилийн тоо яг хэзээ хийх юм бэ? Жоохон урагшлуулаад хийх боломж байгаа юу? Одоо ингээд нөгөө энэ арга хэмжээ чинь нэлээн удаад байна л даа. Миний бид бүхэн бараг 2 сар хэртэй яриад л өнөөдөр Засгийн газар орж ирж байна. Ингээд цаг хугацаа өнгөрөөд байхаар удаад байна.

Тэгэхээр энэ дээр тэр 70 хувиас дээш малаа алдсан иргэдийн гэсэн өрхийн малчин өрхийн гэсэн юм явж байна лээ. Тэгэхээр энийг 70 гэдэг бол хэтэрхий өндөр байна аа. Малын индексжүүлсэн

даатгал дээр бид нар 6 хувь гээд үзэхэд л ер нь жоохон чангахан шиг зудтай жил зургаа хүрдэггүй шүү дээ. Тэгэхээр энэ дээр энийг 50 хувь болгоод бууруулчих ийм боломж байгаа юу энэ малаа алдсан өрхийн асуудал.

Тэгэхээр энэний санхүүгийн эх үүсвэрээ бас хаанаас харж байгаа юм бэ? Тэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд дээр байгаа 22 тэрбум төгрөг чинь тооцоод нэг дорвитойхон малжуулчихъя гэхэд 550-аас 600 өрхөд ч юм уу тийм ээ 150-аас 200 малаар бодоход ийм хэмжээний юм харагдаад байна л даа. Тэгэхээр энэ дээр жоохон дорвитойхон авъя олон өрхийг малжуулах хөтөлбөрт хамруулья гэхэд энэ хөрөнгийн эх үүсвэрийг бас юу гэж харж байгаа вэ гэсэн асуулт байна.

Тэгээд ер нь бол явж явж яг ийм арга хэмжээнээсээ илүү малчдын бэлдээд өгч байгаа түүхий эд бүтээгдэхүүнүүдийг өндөр үнэтэй болгох асуудлыг л шийдчих юм ер нь маш их асуудал шийдэгдэнэ дээ. Тэгэхээр энэ тал дээр ямар бодлого байдаг юм бол гэсэн ийм.

Ж.Батжаргал: Хариулья ажлын хэсгийн нэг.

Д.Амарбаясгалан: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээр 2024 оны төсөвт батлагдсан мөнгөн дүнгээр малчдыг малжуулах хөтөлбөрийг бол зохион байгуулахаар төлөвлөж байна. Яг зориулалтаараа бол 22 орчим тэрбум төгрөг батлагдсанаараа бол байгаа. Мэдээж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан бол нийт дүнгээрээ 107 орчим тэрбум төгрөгтэй. Бүх салбар сегментэд энэ ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэл дээр бодлого хэрэгжүүлэх үүрэгтэйгээр байгуулагдсан байгаа. Батлагдсан байгаа.

Тэгэхээр энэ дээр мэдээж яг энэ эрсдэлээс хамаараад асуудлыг нэг мөр шийдэх гэж бол хичээнэ. Гэхдээ таны хэлдэг шиг нэг айлыг 200 малтай болгох тийм хөтөлбөр хэрэгжүүлэх боломж бол

өнөөдөр батлагдсан төсвийн хүрээнд байхгүй ээ. Тийм учраас Засгийн газар өнөөдрийн энэ уламжлалт мал аж ахуйд уур амьсгалын өөрчлөлтөөс үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах энэ хуулийг оруулж ирж хөнгөлөлттэй зээлийг олгох ажлыг хийнэ. Гэхдээ энэ ажил жилийн жилд юу гэдэг юм бага хэмжээний дэмжлэг үзүүлэхээрээ нэг удаагийн үнэ төлбөргүй мөнгө тараасан нэрээр асуудал шийдвэрлэгдэхгүй юм байна. Цаашидаа энэ мал аж ахуйн салбарт дараалсан жилүүд зуд, дараалсан жилүүдэд бол энэ 60 сая мал хоёр, гуравхан жилийн дотор 30-аас дотогшоо орж ирэх эрсдэл нэгэнт ирчихсэн байгаа учраас бид малчдад малаа та энэ нөхцөлд тэсвэртэй болгох тэр боломжийг нь эдийн засгийн хөшүүргээр нь л хийж өгөх гэж зорьж байгаа юм. Энэ зээлийг хэллээ.

Хориооны гишүүн болсон малчинд олгодог зээл л байна. Хориоо бол сайн дурын үндсэн дээр нэгддэг хуулийн зохицуулалттай ийм нэгж. Тэр хориооны гишүүн бүр ижил тэгш эрхтэй байх ёстой. Хориооны үйл ажиллагааг зөв удирдаж засаглалыг нээлттэй ил тод байлгах бүх нөхцөл боломж нь харин хориооны хуулиараа бол хангалттай сайн хийгдсэн байна лээ. 2021 он, 2022 онд 2 ч удаагийн нэмэлт өөрчлөлтийг оруулж энэ хууль бол өнөөдөр хэрэгжээд үйл ажиллагааг нь бүрэн дүүрэн зохицуулалт хийгээд явах боломж бол хангалттай байна лээ гэж ингэж үзэж байна. Индексжүүлсэн даатгалын тухайд өнөөдөр мэдээж тулгамдсан асуудал малчид малгүй болсон гэж байгаа. Гэхдээ малын хорогдол гарах хугацаа дуусаагүй байгаа шүү дээ Туваан гишүүн ээ. 4 дүгээр сард хэчнээн мал нэмж хорогдох вэ? 5 дугаар сард хэчнээн мал нэмж хорогдох вэ? Магадгүй 6 сарын эхээр ногоо идтэлээ мал хорогддог гэдгийг малчид бүгд мэдэж байгаа. Тэгэхээр энэ нэгдсэн хорогдсон дүн гарсны ард, тооллого хийгдсэний үндсэн дээр энэ чинь өөрөө аль аймгийн аль суманд яаж олгогдох вэ л гэдэг асуудал яригдана.

Энийг өнөөдөр бид урьдчилж тааварлаж юм уу, төсөөлж ярих боломж хараахан алга байна. ОБЕГ-ын эрсдэлийн үнэлгээ, урьдчилсан үнэлгээ, мөн олон улсын байгууллагуудын зүгээс хийсэн үнэлгээ дүгнэлтээр энэ онд 16-аас 18 сая мал хорогдох эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан.

Өнөөдөр 4 сарын 4-ний байдлаар.

Ж.Батжаргал: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Индексжүүлсэн даатгалыг биш тэр нөгөө хагас жилийн тооллого гээд нэг юм ярьсан тэрийг нь л асуусан юм. Тэрэн дээр нэг хариулт авчихъя. Тэгээд энэ нөгөө эхний асуулт бол тэр бодлогын хувьд энэ 2 хууль орж ирж байна л даа. Малчин өрхүүдийн холбооны эрх зүйн байдлын тухай энэ уламжлалт мал аж ахуй гээд энэ 2-ын бодлогыг ер нь яаж уялдуулж явах юм бэ? Яг ингээд зэрэгцээд хоршоо холбоо гээд явж байна. Энэ дээрээ нэг хариулт авчихъя. Тэгээд ер нь нийтдээ төлөвлөлтөө Сангийн яам дүнгээ ер нь юу гэж харж байгаа юм гэсэн ийм асуултууддаа тодорхой хариулт авчихъя аа.

Ажлын бусад хэсгүүдээс ч юм уу яамдаас нь.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн нэг.

Д.Амарбаясгалан: Малчин өрхийн эрх зүйн байдлын тухай хуулийг Улсын Их Хурлын гишүүд боловсруулаад, санаачлаад, өргөн бариад, одоо Улсын Их Хурал дээр хэлэлцээд явж байгаа гэж ойлгож байгаа. Энэ хуулиар бол үндсэндээ эрх зүйн байдлынх нь асуудалд илүү анхаарсан, холбооны зарчмаар ажиллах нөхцөлийг нь хангах юм байна гэж ингэж ойлгож байна. Өнөөдөр орж ирж байгаа хуулиар малчдын аж ахуйн асуудал, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой асуудлын зохицуулалт хийхээр орж ирж

байгаа. Тэгэхээр хоорондоо ямар нэгэн байдлаар давхцах, зөрчилдөх зүйл бол байхгүй гэж төсөл боловсруулахдаа бид бол үзсэн байгаа.

2 дахь зүйл нь энэ малчдад олгогдох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр арилжааны банкны өөрийн эх үүсвэр байх юм. Өөрийн эх үүсвэрээрээ үндсэндээ бол Хаан банк, Төрийн банк зэрэг банк бол 2024 онд 500 гаруй тэрбум төгрөгийг бол гаргах боломж байна гэж ингэж харж байгаа. Засгийн газрын зүгээс энийг дор хаяж 5, 10 бүүр цаашилаад 20 жилийн урт настай хөтөлбөр байх ёстой гэдэг агуулгаар нь өнөөдөр хуулийн төслийг хэрэгжих хугацаагүйгээр тавьж бас орж ирж байгаа. Энэ өөрөө батлагдсаны үндсэн дээр урт хугацаанд хөтөлбөр болоод хэрэгжээд явах боломжтой. Нэг өдөр хоршоо байгуулагдаад нэг жилд энэ асуудал бүгд шийдэгдэхгүй учраас нэг эхлүүлсэн бодлого урт хугацаанд тогтвортой үргэлжлэх ёстой гэж бодож байна.

2 дугаарт нь мал аж ахуйн салбар луу нэг дор их хэмжээний мөнгө орох боломж зах зээл бас хумигдмал. Тэгэхээр энэ жил жилд нийт малчин өрхийн 5 хувь, 10 хувь, 15 хувь, 20 хувь гэх байдлаар зах зээл нь өргөжиж тэлэх, туршилага суух, улам бүр хариуцлагатай болох сайн туршигуудыг цааш нь малчид уламжилж авч явдаг болох зэрэг нь өөрөө энэ хөтөлбөр урт хугацаанд хэрэгжих ёстой юм гэдгийг харуулж байгаа юм.

Монгол Улсад өнөөдөр 5000 гаруй хоршоо бүртгэгдсэн байна. Мал аж ахуйн салбарт 1571 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Тэгвэл эдгээр хоршоодын.../минут дуусав/

Ж.Батжаргал: Мөнхцэцэг гишүүн асуулт асууя.

Г.Мөнхцэцэг: Байгаль цаг уурын өөрчлөлт яалт ч үгүй бас энэ эрсдэлүүд ингээд энэ хөдөө аж ахуйн салбарт тэр тусмаа уламжлалт МАА эрхэлдэг Монгол

Улсын хувьд яалт ч үгүй ийм эрх зүйн зохицуулалтуудыг хийх зайлиггүй шаардлагатай л болоод байна л даа. Тэгэхээр энэ хууль хоорондынхоо уялдаа холбоог бас харах хэрэгтэй байна гэж байгаа. Гишүүдийн хэлж байгаатай би бас санал нэг байна. Зарим гишүүдийн хэлж байгаа тэр төсөв хоорондын зохицуулалтууд байна. Эрх, үүргийн хувьд бас жоохон зөрчилтэй байгаа зүйлүүдийг бас арилгаад ингээд энэ хууль хоорондынхоо уялдааг ингээд аваад явах нь зөв байх гэж бодож байна. Тэгээд энэ хуулийн төслийг угаасаа дэмжиж байна.

Тэгээд тэр өвс тэжээлийн шим бүс нутгаараа өөр байна. Ялангуяа үнэ өөр байна гээд Амарбаясгалан сайд таны хэлж байгаатай бас санал нэг байна. Тэгэхээр өнөөдөр бас яалт ч үгүй арга ч үгүй юм. Сүхбаатарт тариалсан өвс гэдэг юм уу Сэлэнгэд тариалсан өвс өнөөдөр ингээд Дундговь ч юм уу Говьсүмбэрт ч ингээд очихоороо бол тээвэрлэлтийн үнэ шингэчихдэг. Гэсэн хэр нь яг малд идэж бариад тэндээсээ тэнхэл авдаг тийм тэжээл болдог тийм юмнууд бас өөр байдаг гээд ингээд малчид маань хаанаас ирсэн өвс юм, хаанахын өвс юм гэдэг дээр нь илүү их онцлоод бас ингээд яриад байдаг нь үнэн. Тэгээд яг бид нар бас говийн нөхцөлд өөрөө ингээд өвс тариалалт хийе, энд өвс тэжээлийн ийм бүс нутаг байгуулаад га талбай бий болгоод ингээд ажиллая гэхэд зарим нэг аймгийн хувьд ямар нэгэн байдлаар бас малын бэлчээрийн даац хэтэрснээсээ болоод мөн газар нутгийн га талбай багатайгаасаа болоод энэ яг ийм тариалалтын бүс нутаг гэдэг зүйл дээр хамруулаад ингээд явахад малчин өрхүүдэд хүндрэл учирдаг. Жишээлбэл Говьсүмбэр аймаг гэхэд нэлээд хэсэг нь отрын бүсэд байж байдаг. Зарим нэг хэсэг нь Тусгай хамгаалалттай газар нутагт байж байдаг. Тэгэхээр энэ салбар хоорондын, хууль хоорондын нөгөө уялдаа холбоог яаж хангаж ажиллах юм бэ гээд миний асуух гээд байгаа зүйлүүд маань энэ л дээ.

Тэгэхээр отрын бүсэд жишээлбэл тариалалт хийж болох юм уу, үгүй юм уу. Тусгай хамгаалалттай газар нутагт авчихсан байгаа энэ газар нутгуудад жишээлбэл энэ тариалалтыг хийж болох юм уу, үгүй юм уу гээд. Ингээд энэ зүйлүүдийг бас нэлээн харж ажиллах ёстой байх. Энэ хуульд жишээлбэл яаж тусгасан байгаа юм. Хуучнаар ингээд говийн нөхцөлд нэмэгдэл гээд энэ зүйлүүдийг бас ингээд хуулиар зохицуулдаг ийм зохицуулалтууд байгаад байсан. Тэгэхээр энэ яг энэ бүс нутаг дээр нь ямар нэг ямар нэгэн байдлаар ялгамжтай хандаж байгаа ийм зүйлүүд бас байна уу, үгүй юу гэдэг дээр асуулт байна.

Нөгөөдөх нь энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас малгүй болчихсон малчин өрхүүдэд зээл олгоно гээд энэ байж байна. Тэгэхээр энэ зээлийн чинь хүртээмж нь ямар байгаа билээ. Жишээлбэл нэг өрхөд ямар хэмжээтэй зээл олгох юм. Зээлийн хүүг нь яаж зохицуулах юм гээд ямар энэ зохицуулалтууд нь өөрөө яаж тусаж байгаа юм бэ гэдэг зүйл дээр асуулт байна. Энэ дээр бас хариулт авчихъя.

Тэгээд яах вэ малчин өрх өөрсдөө ингээд хоршоодоо байгуулаад, хоршоод ажиллая гэдэг саналуудыг бас олон л тавьж ирсэн л дээ. Тэгэхээр жишээлбэл энэ газраа яаж хоршоод нь сонгох юм уу, малчин өрх нь өөрөө яаж сонгох юм гээд газар сонголт дээрээ. Газар сонголт дээр, жишээлбэл яаж ямар байдлаар зохицуулалтууд хийж байгаа юм бэ гээд энэ зохицуулалтуудыг ер нь яаж хийж байгаа юм бэ гэсэн 2 , асуултуудыг л тавьж хариулт авъя даа.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн нэг.

Д.Амарбаясгалан: Мэдээж бүс нутаг болгон өөр өөрийн онцлогтой байгаа. Өндөр, нам, говь, тал, хангай гээд олон янзын нөхцөлд бол мэдээж байгаа нь тохиромжтой мал аж ахуйгаа үржүүлж

байгаа нь бол тодорхой байгаа. Тэгэхээр энэ бодлого бол заавал сум болгон заавал баг болгон өвс, тэжээлээ тарина, эс үгүй заавал ингэнэ гээд нэг янзын загвар гаргаж загварчлахгүй. Харин үе шат бүрд нь бүс нутгийн онцлог бүрд нь таарсан тохирсон тэр бодлогыг нь дэмжих боломжийг олгож байгаа гэдгээрээ л явна. Говийн аймгийнхан яг өөр өөрийнхөө газар нутгийн онцлогт таарсан тэр аж ахуй тэр юу гэдэг юм нэмүү өртөг шингээх нөхцөлийг бүрдүүлэхэд нь л боломжийг нь олгох энэ зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх гээд байгаа гэсэн үг. Түүнээс биш загварчилж болохгүй шүү дээ. Үхэр үржүүлэх тохиромжгүй бүс нутаг дээр чи заавал үхэр үржүүл гээд сууж байх шаардлага байхгүй гэдгийг маш сайн ойлгох хэрэгтэй юм байгаа юм. Зөвхөн ямаа өсгөх, ямаа тэжээхэд маллахад илүү тохиромжтой бүс нутаг бол тэр лүү нь ноолуур ангилан боловсруулалт хийдэг, ялгадаг, тэр боломжийг нь олгох хэмжээний аж ахуй эрхлэхэд нь хөнгөлөлттэй зээлийг олгоё л гэж байгаа юм.

Зээлийн тухайд би дахиад хэлье. Хоршоонд нэгдсэн малчин өрх 50 хүртэл сая төгрөгийн зээл авах боломжтой. Зээлийн батлан даалтын сан 50 сая төгрөгийн зээл авах гэж байгаа малчин өрхөд 80 хувийн баталгааг гаргаж өгч чадна. 20 хувийнхаа барьцаа баталгааг зээл авч байгаа малчин гаргана. 20 хүртэл сая төгрөгийн зээлийг авахад нь малчин өрхөд бол барьцаа тавихыг эн тэргүүнд шаардахгүй. Гэхдээ тэр зээлийг авах гэж байгаа иргэн хамтран зээлдэгчтэй, зээлд нь баталгаа гаргагчтай байж байж тэр зээл олгогдоно. Авсан зээлээр хийх гэж байгаа зүйлийг би дахиад хэлэхэд шинээр хөрөнгө оруулалт хийхэд нь л хөрөнгө оруулалтын зээл олгоно. Түүнээс хэрэглээний зээл олгогдохгүй. Тэгэхээр шинээр хийгдсэн хөрөнгө оруулалт нь эргээд арилжааны банкны барьцаа болно л гэсэн үг. Тэгэхээр энэ аль аль талаасаа хариуцлагатай ажиллах боломжтой. Өнөөдөр малчдыг амьжиргаагаа дээшлүүл гээд тэгээд байдаг. Ямар

мөнгөөр амьжиргаа дээшлүүлэх вэ. 1 удаа тараах 1, 2 сая төгрөгөөр амьжиргаа нь дээшлэх үү. Малжуулах хөтөлбөр хийж байгаа гээд 5 сая төгрөг өгснөөр малтай болоод амьжиргаа нь дээшлээд чинээлэг амьдрах боломж бүрдэх үү гээд харахаар энэ бол боломжгүй зүйл. Энэ бол 1 удаагийн шинжтэй арга хэмжээ болж ирнэ. Харин хоршоод бизнес эрхлэх боломжийг нь олгож өгснөөрөө чинээлэг малчин, чинээлэг дундаж давхаргыг бий болгох том хөшүүрэг нь болох юм гэдэг энэ агуулга дээр Засгийн газар ажиллаж байна.

Ж.Батжаргал: Анандбазар гишүүн асуултаа асууя.

Ц.Анандбазар: Баярлалаа. Үнэхээр чухал хуулийн төсөл өргөн барьсан байна. Амараа дарга. Ер нь сая энэ зуднаар Засгийн газрын гишүүд маань хөдөө яваад хөдөөгийн малчдын амьдралыг асар сайн ойлгосон. Маш сайн ажил боллоо. Бараг л Засгийн газрын гишүүдийг хөдөөгөөс сонгож байх хуулийн төсөл өргөн баримаар санагдаж байна. Тэгээд загатнасан газар маажив гэдэг шиг чухал хууль учраас дэмжиж байна. Тэгээд энэ хуулийн төсөл дээр нөлөөллийг бууруулах хуулийн төсөл гэсэн ийм хууль, тогтоолын төсөл байгаа юм байна.

Ер нь цаашилаад Амараа дарга ингэвэл яасан юм бэ. Зуд гэдэг үгийг Монгол Улсын Монгол хэлний үгсийн сангаас хасмаар санагдаад байгаа юм. Юу гэсэн үг вэ гэхээр энэ чинь социализмын үед таны энэ хийж байгаа бүх төсөл хоршоолох төсөл бол нэгдэлжих төлөвлөгөөний зах зээлийн хэлбэр шүү дээ. АНУ-ын судлаачид хэлсэн байсан. Монголд 2 том зүйл байсан байна. Нэг нь нүүдлийн МАА, нөгөөдөх нь нэгдэлжих хөдөлгөөн байсан юм байна. Нэгийг нь буулгасан байна гээд судлаачид хэлсэн байсан. Тэгээд судалгаан дээр үндэслэсэн их сайн төсөл болсон байна гэж бодож байна. Тийм учраас яаж энэ зуд гэдэг үгийг Монгол хэлнээс хасах юм бэ гэхээр бидний өмнө хэрэглэж байсан

сайхан туршилага байна. Монгол Улсад маань 48 тэжээлийн аж ахуйтай бүхэл бүтэн бүтэц байсан байна. Энэ 48 тэжээлийн аж ахуйгаар дамжуулаад Монголын 21 аймаг өвлийг хамтын хүчээр давдаг байсан. Зах зээл ороод бүх тэжээлийн аж ахуй дампуурсан. Одоо бид шинэчилсэн сонгуулийн тогтолцоогоор 7 бүс нутаг болж байгаа. Энэ 7 бүс нутагтаа тэжээлийн 1, 1 том аж ахуйг байгуулах нь онцгой чухал болчихоод байна.

Канадад явж байхад танай Монгол улс 70 сая малтай юм бол ямар тэжээлийн ургамал тарьдаг вэ гэж асууж байсан. Тэнд ургамал тарьдаггүй юм. Бид бурхандаа найдаад л явдаг юм гэдэг ийм хариултаас өөр юмгүй болсон шүү дээ. Тэгэхээр хэрвээ энэ малынхаа аманд юм хийгээд өгөх юм бол өвөл зуд гэж үг байхгүй гэдгийг олон сумын буриадууд, хөдөлмөрч хүмүүсээс харж байгаа. Тэгэхээр энэ 7 бүс дээр жишээлбэл хойд бүс дээр Булган, Хөвсгөл, Эрдэнэт дээр миний эхлүүлсэн байгаа Бор булангийн төслийг дэмжмээр байгаа юм. Зүүн бүс дээр манай Түмэнцогтын сангийн аж ахуй гээд бэлэн сангийн аж ахуй байна. Хойд бүс дээр Өвөрхангайн Хархорины усалгаатай талбай байж байна. Баруун бүс дээр Тайширын цахилгаан станцыг дагуулаад том тэжээлийн аж ахуй хийчихмээр байна. Хэрвээ ингэж чадах юм бол нэгмөсөн тэр өвсний асуудал, тэжээлийн асуудлыг шийдэж болно. Жишээ нь Бор булан дээр 600-700 мянган боодол тэжээлийн ургамал тарьж болж байгаа шүү дээ. Энэ нь 5 аймгийг хангах хүчин чадалтай байхгүй юу. Тэжээлийн ургамал чинь өөрөө 1 боодол нь 14 боодол цагаан өвстэй тэнцэж байна.

Тэгээд та түрүүн их сайн юм ярьж байна. Яагаад гэхээр тэр нөгөө газар газрын өвс ургамлын чанараас хамаараад нөгөө малын таргалалтад нөлөөлж чадахгүй байна гэж. Үнэхээр шинжлэх ухааны үндэстэй зүйл. Тэгэхээр тухайн бүс нутагт нь тэжээл ургамал тарих юм

бол үнэхээр чухал. Одоо царгас гээд тэжээлийн хаан гэж ургамал байна. Мал аж ахуйтай улс болгон тарьдаг. Энэ нэлээн олон жил ярьсан.

Харин энэ жил зуд болж байж бид нэлээн сайн ойлголоо. Тэгэхээр энэ тал дээр та бүсчилсэн тойрог болсон асуудал дээр энэ аймгуудын дундах тэжээлийн аж ахуйг байгуулах ямар дорвитой бодол бодож байна вэ. Энийг 1 дүгээрт асуумаар байна. Энэ эргээд тэр жишжиг нөгөө ногоон ургамал тарих малчдыг дэмжих ийм төсөл болно. Ингэх юм нөгөө малчид дээр ирэх эрсдэл ч багасах байх гэж бодож байгаа.

2 дугаарт малчдад өгч байгаа зээлийг бизнесийн утгаар нь өгч байгаа нь их чухал болж байна. Одоо энийг амьдралд нь хүртээмжтэй болгох талаар бодох ёстой юм. Хэрвээ ингэж хүртээмжтэй болгож чадах юм бол таны энэ төсөл нэг.../минут дуусав/

Ж.Батжаргал: Дийлэнх нь санал болчих шиг л болох юм. Асуулт байгаа юм уу. Ер нь харагдаагүй дээ. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Д.Амарбаясгалан: Тэжээлийн аж ахуй ер нь байгуулах шаардлага бол угаасаа бүс нутагт байгаа юм. Одоо нэг зүйлийг бүгдээрээ их сайн ойлгомоор байгаад байгаа юм. Ерөөсөө хувийн хэвшил, иргэд, малчид өөрсдөө хийх шаардлагатай олон зүйлийг нь хийх боломжийг нь л гаргаж өгье гэдэг дээр л төвлөрөх ёстой. Тэгэхгүйгээр тэжээлийн аж ахуйг нь төр байгуулъя. Тэрийг нь төр байгуулъя гэдэг энэ бодлоосоо жсоохон ангид байгаад, энэ нь өөрөө бизнес, энэ нь өөрөө зах зээлийн зарчмаар явах ёстой юм гэдэг агуулга дээр нь тодорхой хэмжээнд төвлөрөөд, харин энэ бүгдийгээ хийх боломжийг нь урт хугацааны хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгож өгөх нь хамгийн чухал юм аа.

Цаашидаа байгаль цаг уурын энэ сөрөг нөлөөлд тэсвэртэй байдаг хагас

эрчимжсэн өвс тэжээлээсээ уураг тэжээлээ бүрэн авч чаддаг, өөрөө үнэд хүрчих мал, мал аж ахуйтай салбар болох ёстой. ДНБ-д үзүүлж байгаа нөлөөлөл нь 10,5 хувьтай байна. Энийг тогтвортой урт хугацаанд бодитой хийж чадах юм бол 10-хан жилийн дотор 30 хувьд хүрээд ирэх боломж нээлттэй байна. Яг ингээж хийж хэрэгжүүлсэн улсын жишээ ч бас байна. Шинэ Зеланд улсын жишээ 20 жилийн дотор 5-6 дахин үр өгөөжтэй салбар болгож хувиргаж чадсан байна. Тэгэхээр энэ боломжийн төлөө л бид өнөөдөр мал аж ахуйн салбар дээр тодорхой хэмжээний либералчлалын бодлогыг хийж өгч байна л гэж ингээж л ойлгох хэрэгтэй. Тэгэхгүйгээр төр очоод л хашааг нь барина гэх юм уу, өвс тэжээлийг нь тарина гэх юм уу, тэр өвс тэжээлийг нь боловсруулах үйлдвэр байгуулна гэх юм уу ингээд ороод ирэхээрээ энэ асуудал бас энэ зах зээлийнхээ тодорхой зарчмаас бол ухрах, алдагдах ийм нөхцөл рүү орж байгаа юм

Засгийн газар өнөөдөр энэ хуулиар дахиад хэлэхэд малчдадаа урт хугацаанд хэрэгжүүлэх хөтөлбөр болгож нэг гаргаж өгнө. 2 дугаарт хөнгөлөлттэй зээлийг урт хугацаанд авч, аж ахуйн үйл ажиллагаа явуулах боломжийг нь бүрдүүлж өгнө. Тэр аж ахуйн үйл ажиллагаа зөвхөн мал маллах байхгүй. Малын нэмүү өртөг шингэх олон талын боломжийг бий болгох тэр зорилгыг бас агуулах юм.

Ж.Батжаргал: Анандбазар гишүүн тодруулъя.

Ц.Анандбазар: Тэр тэжээлийн аж ахуйг төрөөс байгуулахгүй. Тэрэнтэй санал нэг байна. Тэжээлийн аж ахуй бүрэн нурсан байгаа учраас жишээ нь усалгааны системийн даланг нь сэргээж өгөх ёстой юм. Ингэх юм бол нэг дор 7000 гатай маш сайхан аж ахуйн нэгжүүд байна. Тэрийгээ малчдад тарих эрхийг нь өгөөд хуваагаад өгчих ёстой юм. Ингэх юм бол хамгийн зөв бүтэц болж байгаа юм. Тэгэхгүй дэд бүтцийг байгуулахад

асар их хөрөнгө болж байна шүү дээ. Тэнд малчид орохгүй, бэлэн усалгаатай, бэлэн дэд бүтэцтэй, хөрс нь таарсан шинжлэх ухааны үндэстэй талбайнууд байгаа юм. Тэгэхээр энэ бүсчилсэн хөгжлийн дагуу 7 ийм тэжээлийн аж ахуйн дэд бүтцийг байгуулаад өгөөч л гэж байгаа юм. Энэ онцгой чухал юм.

Ж.Батжаргал: Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Энэ хуулийг дэмжиж байгаа. Үнэхээр юу гэдэг юм энэ цас зудны аюул, үер усны аюул гээд ер нь энэ байгаль цаг уурын эрсдэлийн аюул бол жилээс жилд нэмэгдэж байна. Тэгэхээр цаашидаа малчид маань хоршоод нийлэх, нөхөрлөл байгуулах, хамтаараа энэ цас зудны, үер усны аюултай тэмцдэг, нийлж байгаад мах шөлөө борлуулдаг, хадлан тэжээлээ бэлддэг, ноосоо боловсруулдаг, ийм нэмүү өртөг шингэсэн ийм үйлдвэрлэлийн чиглэлээр, аж ахуйн чиглэлээр бизнесийн чиглэл рүү орж байгаа ийм хууль байна гэж ингээж дэмжиж байгаа.

Асуух нэг зүйл байж байгаа. Ер нь энэ хууль нэлээн чанартай сайн хууль болжээ. Хамгийн гол нь энэ хуулийг олон нийтэд сурталчлах, таниулах энэ ажлыг л бас хангалттай сайн түвшинд хийх хэрэгтэй. Ер нь бид нар маш олон хуулиуд гаргадаг. Харамсалтай нь ингээд доод шатдаа яг иргэддээ хүрч чадахгүйгээр маш олон хууль ингээд байж байна. Тэгэхээр энийг юу гэдэг юм малчин өрхөд таниулах, сум, орон нутгийн иргэдэд таниулах энэ сурталчилгааг, энэ ажлыг л сайтар зохион байгуулах хэрэгтэй байх л гэж бодож байна. Тэгээд мэдээлэлтэй ойр байгаа нөхдүүд нь хоршоо байгуулаад их хэмжээний зээл авдаг, мэдээллээс хол байж байгаа, хол оршиж байгаа энэ хүмүүс нь мэдээлэл авч чаддаггүй ингээд юмнаас хоцордог ийм байдал юу гэдэг юм манай Монгол Улсад түгээмэл байна л даа. Тийм учраас энэ мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах, энэ ажлуудыг сайтар бүх түвшинд нь зохион байгуулах

шаардлагатай байх гэсэн ийм бодолтой явж байна.

2 дахь асуудал зүгээр энэ хууль дээр үнэхээр манай говийн бүс дээр хадлангийн салаанууд их байдаг. Бид тэр трактор, комбайн, хадлангийн тэр багаж тоног төхөөрөмжийг нь аваад өгчихсөн байдаг. Тэгээд говьд юу гэдэг юм хадлан тэжээлээ бэлтгэх ийм бололцоо боломж байдаггүй. Тэгээд нөгөө хангайн бүс, зүүн бүсийн аймгуудтай бас ярьдаг. Харамсалтай нь нөгөө сумын ИТХ нь газраа өгдөггүй, хадлан тэжээлээ бас бэлдүүлдэггүй нэг ийм асуудал байгаад байдаг. Тэгэхээр энэ хууль дээр болж өгвөл энэ зүүн аймгууд болон хангайн аймгууд, говийн бүсийн аймгууд нь үнэхээр хадлан тэжээлээ бэлдэх гээд ирэхэд нь тодорхой хэсгийг бас зааж өгдөг ийм бололцоо боломж эрх зүйн орчныг бас нээгээд өгвөл илүү их бас хэрэгтэй юм болов уу гэсэн ийм бодолтой байгаад байгаа юм.

2 дахь асуудал энэ бол мэдээж энэ малынхаа үүлдэр угсааг сайжруулах, таваарлаг болгох энэ ажлуудыг шат шатад нь хийх хэрэгтэй. Тийм учраас энэ аймаг болгоны Хөдөө аж ахуйн газрын дэргэд ч гэдэг юм уу энэ цөм сүргийг л байгуулж өгвөл бас илүү их үр дүнтэй юм болов уу гэж бодоод байна. Тэгээд аймаг болгон дээр юу гэдэг юм тэр сайн үйлдвэрийн мал нь байж байдаг. Сайн үйлдвэрийн тэр хуц ухна нь байж байдаг. Таваарлаг тэр мал нь байж байх юм бол хол явахгүйгээр нөгөө хоршоод маань аймгийн төв дээрээсээ очоод энэ үржил селекцийнхээ ажлыг хийгээд, үүлдэр угсаагаа сайжруулаад байх ийм бололцоо боломж бас байгаад байгаа юм. Тэгэхээр энийг бас бас энэ хууль дээр бас нээгээд өгвөл бас илүү их үр дүнтэй юм болов уу гэсэн ийм бодолтой байж байна. Тэгээд энэ хуулийг дэмжиж байна.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн нэг. Ер нь ихэнх нь санал байлаа. Хариулах юм бий юу. Тэгвэл Цэрэнпунцаг гишүүн асуулт асууя.

Ц.Цэрэнпунцаг: Энэ хамгийн гол нь Зээлийн батлан даалтын сан чинь яг өөрийнхөө батлан даалтын санд байгаа нийт боломжоос 2 дахин бага, 200 хувийн баталгаа гаргах юм байна лээ шүү дээ. Ер нь тэгэхээр зэрэг Зээлийн батлан даалтын сан чинь 2 эх үүсвэр нэг нь энэ сайдын багцаас орж ирж байгаа. Төсвөөс орж ирж байгаа. 1 нь олон улсын байгууллагуудын энэ удаан хугацаанд зээлээр орж ирж байгаа юм байна. Тэгэхээр цаашид энэ зээлийн батлан даалтын сангаа бас зузаатгах ийм шаардлага гарч байгаа. Энийг ер нь яаж шийдэх юм алсдаа бол. Дээрээс нь ингээд Зээлийн батлан даалтын сан гээд 100 хувь хүртэл ингээд заримыг нь 100 хувь батлан даалт гаргана гээд явчихаар зэрэг банкнууд жоохон өөрсдийн зүгээс арилжааны банкнууд чинь шалгуур үзүүлэлт нь суларна. Нөгөө зээлүүд дээрээ зээлийнхээ процессыг явуулахдаа жоохон сул нэгэнт баталгаатай юм чинь гээд хандах болов уу.

Тэгэхээр зэрэг энэ тал дээр уяж өгөх талдаа яг яаж та бүхэн нарийн уяж өгч байна. Шаардлагыг нь яаж хатууруулах юм. Хатуу болохоор чинь бас авч чадахаа больчихно тийм ээ, бүр хэтэрхий амьдралгүй бас хэтэрхий зөөлөн байж болохгүй. Тэгэхээр зэрэг энэ олон шаардлагууд дунд би бас анх энэ танил энэ төслийг танилцуулж байхад хэлж байсан юм. Энэ бэлчээрийг хамгаалахтай холбоотой, бэлчээрийг ашиглалтыг зүй зохистой ашиглах, малынхаа сүргийн бүтцийг зүй зохистой хадгалах гээд энэ олон шаардлагуудыг л энэ хуульдаа нарийвчлаад тусгах тийм боломж бий юу гэж. Жишээлбэл бид нар сүргийнхээ орон нутаг, сум багаар нь, сумаар нь говийн бүс бол говийн бүс, хангайн бүс бол хангайн бүс. Тэгэхдээ болж өгвөл сайн нарийвчлаад хангайн бүс ч гэсэн дотроо олон ялгавартай ангилж болно. Тэгэхээр эд нарыг нь бид нар нэг стандарт тогтоогоод шалгуур үзүүлэлтүүдийг нь сайн тавьж өгөөд тэгээд энийгээ нөгөө батлан даалтынхаа сангаас гаргах,

баталгааныхаа 50 хувь гаргах юм уу, 60 хувь гаргах юм уу, 100 хүртэл гаргах уу гэдэгтэйгээ уяж өгвөл яасан юм бэ. Энэ дээр ажиллах тийм боломж бий юу. Энэ дээр ажиллаж байгаа Хөдөө аж ахуйн яамныхан маань энийгээ бэлчээртэй нь хамгаалахтай нь бид нар уяад өгөх юм бол нэгэнт цаашидаа бид нар бэлчээрээ хамгаалахын тулд төсвөөс мөнгө зарна. Энэ дэлхийн дулаарал гэдэг юм яваад л байвал энэ битгий хэл их мөнгө зарна.

Тийм учраас бид нар нэгэнт ирээдүйд гарах тэр эрсдэл ингээд тулчхаад, илт ойлгомжтой болчихоод байгаа үед одоо бид нар урьдчилж заримыг нь гаргая л гэж байгаа л үг болно шүү дээ. Тэгэхээр энийгээ ер нь гол нь нөгөө ашгаа буцааж яаж төлөх вэ гэсэн шаардлагуудаасаа илүү байгаль орчных нь байгаль бэлчээрээ хамгаалахтай нь их сайн уяад, тэгээд тэрэнтэйгээ өндөр сайн шалгуур хангаад хамгаалж явбал нөгөө талдаа зээлийн батлан даалтынхаа сан дээр гаргаж байгаа баталгаагаа нэмээд явдаг энэ хоёрыгоо холбочихвол цаашидаа бид нар бас ОУБ-аас энэ чиглэлээр эх үүсвэрүүд бий болох, оруулж ирэх ийм боломжууд байгаа. Яагаад гэвэл бид нар чинь Байгаль хамгаалах консервац бүлгийнхэн гээд 10 хэдэн гишүүн байгаа. Бид нар ингээд гадна, дотнын бас олон улсын парламент энэ хууль тогтоогчидтой ажиллаж байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар их сайхан зөв бодлого гаргаад энийгээ уяад ирэх юм байгалиа хамгаалаад эхлэх юм бол энэ дээр ажиллаж болохоор байгаа юм. Тэгэхээр энэ дээр л та бүхэн яг хууль дээрээ уяад өгчих. Дараа нь журам бас тодорхой бид нар араас нь зарим журам бас тэгээд 2, 3 гарцтай болчихоод байдаг. Хууль дээрээ тодорхой юмнууд зааж өгмөөр байна л гэж байна. Энэ боломж байна уу, үгүй юу гэж асуух гэсэн юм.

Ж.Батжаргал: Санал хэлж байгаа. Ард дээр нь боломж байна уу, үгүй юу гэж байгаа юм уу. Ажлын хэсгийн нэг.

Д.Амарбаясгалан: Боломж байгаа. Цэрэнпунцаг гишүүн боломж байгаа.

Ж.Батжаргал: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хэлэх гишүүд байна уу. Болорчулуун гишүүнээр тасаллаа. Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Энэ хоршоо жинхэнэ утгаараа малчид хоршиж ажиллах, мөн цаг агаарын бэрхиээлийг хамтдаа даван туулах гол арга зам нь бол ногоон тэжээл тариалах, тэжээлийн ургамал хамтарч тариалах л даа. Тэгэхээр тэжээлийн ургамал хамтарч тариалахад газрын асуудал юу юунаас одоо чухал. Шуурхай бид нар бас энэ хууль дээрээ ч гэсэн нээж өгч арга замыг нь зааж өгч бас ажиллах хэрэгтэй гэж бодож байна. Энэ дээр юу гэвэл хуучин нэгд социализмын үед тэр газар тариалангийн газрын судалгаа хийгээд, тэр маш сайн судалгаа хийдэг байсан юм. Дандаа хөрсний дээж авч судалгаа хийчихсэн газрууд ангилал нь газар тариалангийн газраар бэлчээр лүү шилжчихсэн их байна. Яг амьдрал дээр. Тэрийг эргэж газар тариалангаараа хэлбэрт нь оруулах, мөн одоо байгаа газар тариалангийн талбайг нэмэгдүүлэхийг Засгийн газар тогтоол чиглэл очсон л доо. 10 хувиар нэмэгдүүлэх, мөн газар авчхаад өөрөө ч тарихгүй, хүн ч тариулахгүй ийм газрууд байгаа. Компаниуд. Энэ хуулиараа 2 жил зориулалтаар нь ашиглаагүй бол хурааж авах хуультай байдаг. Энэ сайн хэрэгждэггүй. Тэгэхээр 2 жилд тухайн газрыг авчхаад зориулалтаар нь ашиглаагүй бол хурааж авах дээр бүх шатны дарга нарт үүрэг чиглэл энэ хууль дээр тодорхой заагаад өгвөл энэ нөхөрлөл хоршоо ажиллах, ногоон тэжээл тарих энэ явдал эрс нэмэгдэнэ гэдгийг бас хэлэх байна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Надад 2, 3 санал байгаа юм. Үзэл баримтлалынх нь хувьд хэлэлцэхийг энэ хуулийн төслийг дэмжье. Хэлэлцүүлгийн түвшинд анхаармаар зүйлүүд байна. Монгол Улс

өөрөө эрс тэс уур амьсгалтай улс орон. Тийм учраас чадахгүйдээ биш болохгүйдээ байгаад байгаа юмнууд бас байгаад байгаа байхгүй юу.

Тийм учраас үүнийг нэлээн онцгой анхаарч ажиллах ёстой гэж ингэж ойлгож байна. Тэр 5 га энэ тэр юмнуудыг эргээж нэлээн хараарай. Бид энэ таримал ургамлын үйл явцыг газар тариалангийнхаа хуулиар зохицуулж явж байгаа шүү. Тэр хуульдаа л оруулах ёстой зүйлүүдээ оруулах ёстой. Харин тэр тухайн сум орон нутагт байж байгаа малчдын хоршоо холбоод нь тэр өөрийнхөө газар тариалангийн ангилалд байж байгаа талбайгаасаа давын өмнө тариалах эрхээ эдэлдэг заалтыг л оруулах ёстой. Тэрнээс биш хэдүүлээ шинжлэх ухааны байгууллагууд тогтоогдоогүй газрууд дээр атар газар хагалах тухай эрх нээж таарахгүй ээ. Үүнийгээ нэг онцгой анхаараарай гэж. Нэг ийм зүйл байгаа.

2 дахь зүйл. Сая орон нутагт би нэлээн ажиллалаа. Улсын хэмжээнд нэг айхтар зүйл тулж байгаа юм байна. Энэ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, тэр зөвшөөрлийн тухай хууль 2-ын хөндлөн хайчинд тусгай хамгаалалттай газар нутагт уламжлалт мал аж ахуйгаа эрхэлж байгаа нутгийн иргэдийн эрх ашиг нэлээн хязгаарлагдчихсан юм байна. Өвөлжөө хаваржааных нь газрын гэрчилгээг сунгаж өгөхгүй байж байгаад хугацааг нь дуусгачхаад одоо таны хугацаа дуусаад 2 жил болсон байна. Шинээр авах асуудал яригдана. Шинээр авахын тулд та нэг бол дуудлага худалдаагаар, нэг бол төсөл сонгон шалгаруулалтаар гэдэг юм ярьж байна. Өвөг дээдсээсээ уламжлаад хэдэн 100 жилээрээ уламжилчихсан энэ өвөлжөө, хаваржааг нь гэрчилгээжүүлж өгдөггүй. Үүнээс болоод тэр иргэд оршин суух хаяггүй болчихсон, иргэдээ хүүхэд шуухдаа өөр дээрээ шилжүүлж ирдэг юм байхгүй болчихсон. Ингээд иргэний үйлчилгээний асуудлууд нэлээн хязгаартай болчихсон ийм зүйлүүд хүртэл байна.

Тийм учраас үүнийг бас дагуулж гарах тогтоол юм дээр нэлээн их тодорхой оруулж, нэг мөр шийдэх ёстой асуудал байна. Энэ бол Төв аймгийн Эрдэнэ сумд байгаа асуудал биш юм билээ. Улсын хэмжээнд энэ тусгай хамгаалалттай газар нутаг чинь 120 нэгж талбар, нийтдээ 32 сая га газар байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр үүний асуудлыг их зөв харж, зөв шийдэхгүй бол болохгүй нь гэж. Малжуулах юмыг манай гишүүд яриад байгаа. Өнөөдөр, маргаашгүй юм яриад байгаа. Малын хорогдол дуусах хугацааны тухай нэг бодох ёстой. Малжуулах гээд байгаа мал нь өөрөө бас нэг тэвээрэг юмаа авчихсан, авч байгаа хүн бас нэг сэтгэл өег авах тухай асуудал байх ёстой.

Ингээд бодохоор тодорхой хугацаагаар тасалбар болгож аль аймгийн, аль сумд хэн гэдэг малчин ямар хохирол амсчихсан тэр хүнд ямар хэмжээний хөтөлбөр юм хэрэгжих ёстой вэ гэдэг юм тодорхой болчихсон. Тэгээд тэр малжуулах гээд байгаа үйл явц нь өөрөө үр дүнтэй байх тэр цаг хугацаа юмнуудаа харна шүү, хэдүүлээ. Тэгэхгүй бол энэ бас болж өгөхгүй байгаад байгаа ийм зүйлүүд байна аа. Энэ мэтийг хэлэлцүүлгийн түвшинд манайхан бас анхаараарай гэж ингэж хэлмээр байна.

Ингээд Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 86.7 хувиар хэлэлцэхийг дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Мөнхцэцэг гишүүн танилцуулъя. Анандбазар гишүүнийг дэмжсэнээр протоколд аваарай.

14.56 цагт

Байнгын хорооны хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүддээ болон ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг өндөрлүүлж байна.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА